



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЖУРМЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар
2022 он



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЖУРМЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар
2022 он

Эмхэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны
Хяналт шалгалт, зохицуулалтын газрын
Мөнгө угаахтай тэмцэх алба

ӨМНӨХ ҮГ

Шинэ технологи, цахим эриний хувьсал асар хурдтайгаар өөрчлөгдөж буй өнөө цагт виртуал хөрөнгө гэх ойлголт бий болж санхүүгийн зах зээлд томоохон эргэлтийг авчирснаар бид цахим технологид суурилсан виртуал хөрөнгийн салбарыг таньж ойлгох, тухайн зах зээлийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах амаргүй сорилтын жилүүд тохиож байна.

Дэлхий даяар виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ түгээмэл хэрэглээ болохын хэрээр түүнийг зохицуулах, хянах, үйлчлүүлэгчдийн эрх ашиг болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах асуудлаар улс орнуудын зохицуулагч байгууллагууд анхаарлаа хандуулж эхэлсэн.

Энэ салбарын хөгжил нь уламжлалт санхүүгийн хэрэгслүүдтэй харьцуулахад аливаа гүйлгээг хил хязгаар хамаарахгүйгээр хурдан шуурхай, зардал багатайгаар шилжүүлэх боломжийг олгож байгаа ч, зохицуулалтын орчин бүрдээгүй нөхцөлд хууль бус хөрөнгийн шилжүүлэг, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн эрсдэлийг дагуулж байна. Иймээс 2021 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг тогтоогч байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас “Зөвлөмж 15: Шинэ технологийг шинэчлэн, виртуал хөрөнгийн тодорхойлолт, авах арга хэмжээ”-г тодорхойлсон.

Монгол Улс нь Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн орны хувьд ФАТФ-аас гаргасан Зөвлөмж, стандартыг мөрдөх үүрэгтэй бөгөөд үүний хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах замаар энэ салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэхээр ажилласны үр дүнд Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тухай хуулийг баталж, холбогдох нэр бүхий 13 хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсан билээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь дээрх хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой нэр бүхий 8 журмыг батлан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, энэ салбарын бусад оролцогчдыг дээр дурдсан хууль тогтоомж, журам бүхий нэгдсэн гарын авлагаар хангах нь төрийн зохицуулагч байгууллагын зүгээс уг салбарын зохицуулалтын талаар оролцогч талуудад нэгдсэн мэдээлэл өгөх чухал ач холбогдолтой гэж үзэн энэхүү эмхэтгэлийг толилуулж байгааг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай.....	8
Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай.....	19
Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.....	20
Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай	22
Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай	23
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай.....	25
Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	26
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай.....	28
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.....	29
Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ..	30
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай.....	31
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.....	32
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай.....	33
Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай.....	34
Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай.....	35

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС БАТАЛСАН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМУУД

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 174 дүгээр тогтоол).....	38
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 175 дугаар тогтоол).....	53

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 176 дугаар тогтоол).....	64
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 177 дугаар тогтоол).....	74
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 305 дугаар тогтоол).....	83
Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасах журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 306 дугаар тогтоол).....	89
Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 179 дүгээр тогтоол).....	93
Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам (Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 211 дүгээр тогтоол).....	115

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖУУД**





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж

2.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар Монгол Улсад бүртгэлтэй компани Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улс рүү энэ хуульд заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний харилцагчийн хооронд хийгдсэн гэрээ, хэлцлээс үүсэх маргаантай холбогдсон харилцааг

энэ хуулиар зохицуулахгүй.

4 дүгээр зүйл.Нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“виртуал хөрөнгө” гэж аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг;

4.1.2.“виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч” гэж энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхэлж байгаа компанийг;

4.1.3.“харилцагч” гэж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс үйлчилгээ авч байгаа этгээдийг;

4.1.4.“холбогдох этгээд” гэж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эцсийн өмчлөгч, хуулийн этгээдийн хувьцааны тав, түүнээс дээш хувийг эзэмшдэг хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн нэгдлийг;

4.1.5.“эцсийн өмчлөгч” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан хүнийг.

5 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээнд баримтлах зарчим

5.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээнд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хууль дээдлэх, бизнесийн ёс зүйг эрхэмлэх;

5.1.2.зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж, удирдлага зохион байгуулалтыг үр дүнтэй явуулах;

5.1.3.өөрийн үйл ажиллагаа болон харилцагчийн эрсдэлийг тодорхойлох, тохирсон эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байх;

5.1.4.хуульд заасан шаардлагыг хангаж ажиллах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

6 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ

6.1.Хүн, хуулийн этгээд гэрээ, хэлцэлд оролцогчийн нэрийн өмнөөс, тэдгээрийн захиалгаар, эсхүл тэдгээрт зориулан үзүүлэх виртуал хөрөнгийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна:

6.1.1.виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих;

6.1.2.нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих;

6.1.3.виртуал хөрөнгийг шилжүүлэх;

6.1.4.виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах;

6.1.5.виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх.

6.2.Виртуал хөрөнгийг энэ хуулийн 6.1.5-д заасан үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн компаниар дамжуулахгүйгээр нийтэд санал болгох, худалдахыг хориглоно.

Тайлбар: -Энэ хуулийн 6.1.3-т заасан “виртуал хөрөнгийг шилжүүлэх” гэж бусдын нэрийн өмнөөс виртуал хөрөнгийг виртуал хөрөнгийн данс /хаяг/ хооронд шилжүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

7 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага

7.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагч дараах шаардлагыг хангасан байна:

7.1.1. тухайн компанийн үзүүлэх үйлчилгээ энэ хуулийн 6.1-д заасан виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарсан байх;

7.1.2. виртуал хөрөнгийн үйлчилгээнд ашиглах мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх;

7.1.3. хүсэлт гаргагч болон хүсэлтэд дурдсан үйл ажиллагаатай холбогдох бусад этгээдийн мэдээлэл тодорхой байх;

7.1.4. тухайн үйл ажиллагааны дөрвөн жилийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааг явуулах бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөцтэй байх;

7.1.5. дотоод хяналтын болон мэдээллийг хадгалах системтэй байх;

7.1.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системтэй байх;

7.1.7. өөрийн болон хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр хууль ёсны байх;

7.1.8. тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологитой холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийсэн байх;

7.1.9. мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх;

7.1.10. үйл ажиллагаагаа зогсоох, татан буулгах шийдвэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байх;

7.1.11. татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн, татвар төлөгчийн дугаартай байх;

7.1.12. татварын өргүй тухай татварын албаны тодорхойлолт;

7.1.13. Татварын ерөнхий хуулийн 28.2-т заасан стандартын шаардлага хангасан төхөөрөмж хэрэглэх;

7.1.14. улсын тэмдэгтийн хураамж, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн байх;

7.1.15. энэ хуулийн 7.2-т заасан шаардлагыг хангасан байх;

7.1.16. Хороо шаардлагатай гэж үзвэл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.12-т заасан журмын дагуу Сэндбокст үйл ажиллагаа явуулж, амжилттай гарсан байх;

7.1.17. хуульд заасан бусад.

7.2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэх удирдлага болон Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан дараах шаардлагыг хангасан байна:

7.2.1. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

7.2.2. мөнгө угаах, мөнгө угаах гэмт хэрэгт холбогдуулан шалгагдсан бусад гэмт хэрэг, терроризм, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдоогүй байх;

7.2.3. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь тухайн бизнесийн үйл ажиллагааг эрхлэхэд харшлахгүй байх;

7.2.4. санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын нэг, эсхүл хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн байх;

7.2.5. хуульд заасан бусад.

7.3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн хөрөнгөтэй байх бөгөөд өөрийн хөрөнгийн хэмжээг Хороо тогтооно.

7.4. Энэ хуулийн 7.3-т заасан өөрийн хөрөнгөд гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө хамаарахгүй.

7.5. Холбогдох этгээд энэ хуулийн 7.2.1, 7.2.2, 7.2.3-т заасан шаардлагыг хангасан байна.

7.6. Энэ хуульд заасны дагуу бүртгүүлээгүй этгээд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

7.7. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

8 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг

8.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дараах үүрэгтэй:

8.1.1. үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө болон үйл ажиллагаа эрхлэхдээ хуульд заасан болон Хорооноос тогтоосон шаардлагыг бүрэн хангаж ажиллах;

8.1.2. харилцагчийн эрх ашгийг зохих ёсоор хамгаалж, харилцагчтай шударга, ойлгомжтой, төөрөгдөлд оруулахгүйгээр харилцах;

8.1.3. энэ хуулийн 9.1.8, 9.1.9, 9.1.10, 9.1.11, 9.1.12, 9.1.13-т заасан эрсдэлийн талаарх мэдээллийг харилцагчид гэрээ байгуулахаас өмнө мэдэгдэх;

8.1.4. өөрийн харилцагчийн тухайн үйлчилгээнд хамаарах виртуал хөрөнгө болон мөнгөн хөрөнгийг гүйлгээ хийх, шилжүүлэх, арилжих, хадгалах, удирдах нөхцөл, боломжийг тасралтгүй хангаж ажиллах;

8.1.5. энэ хуулийн 8.1.4-т заасан үүргийг биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг хариуцах;

8.1.6. харилцагчийн мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн данс /хаяг/-ыг үйлчилгээ үзүүлэгчийн данснаас тусад нь байршуулж ажиллах;

8.1.7. энэ хуулийн 7.1.4-т заасан бизнес төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд хүргүүлэх;

8.1.8. энэ хуулийн 4.1.4, 7.2-т заасан этгээд өөрчлөгдөх бол Хорооноос баталсан журмын дагуу хүсэлтээ урьдчилан гаргаж, шийдвэрлүүлэх;

8.1.9. Хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг түр зогсоосон, эсхүл бүртгэлээс хассан бол энэ талаарх мэдээллийг өөрийн харилцагчдад нэн даруй мэдэгдэх.

8.2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, энэ хуулийн 4.1.4, 7.2-т заасан этгээд, ажилтан нь Хороо, түүний хянан шалгагчийн хуулиар олгогдсон бүрэн

эрхийнхээ хүрээнд шаардсан баримт, мэдээ, мэдээллийг саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гарган өгч, хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар шуурхай явуулах нөхцөлөөр хангана.

8.3.Хороо, түүний хянан шалгагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шаардсан баримт, мэдээ, мэдээлэл байхгүй бол энэ тухай тайлбараа энэ хуулийн 7.2-т заасан этгээд албан бичгээр мэдэгдэнэ.

8.4.Харилцагчийн мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн данс /хаяг/-н дахь хөрөнгийг харилцагч, эсхүл харилцагчаас эрх олгосон итгэмжлэл бүхий этгээд захиран зарцуулах эрхтэй.

8.5.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээс бусад зорилгоор харилцагчийн мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн данс /хаяг/-н дахь хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

8.6.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөх ба жил бүр санхүүгийн тайландаа Хороонд бүртгүүлсэн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж Хороонд хүргүүлнэ.

9 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ

9.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч харилцагчийн хооронд байгуулсан гэрээ, хэлцэлд дараах нөхцөлийг заавал тусгаж, хүлээн зөвшөөрснийг баталгаажуулна:

9.1.1. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох төлөвлөгөө;

9.1.2. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүртгэлээс хасагдаж, үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд авах арга хэмжээ;

9.1.3. виртуал хөрөнгө нь хууль ёсны мөнгөн тэмдэгтэд хамаарахгүй, эсхүл Төв банк, эсхүл Засгийн газраас баталгаажихгүй талаарх мэдээлэл;

9.1.4. виртуал хөрөнгө нь хадгаламжийн даатгал, үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг хамгаалах аливаа даатгалд хамаардаггүй талаарх мэдээлэл;

9.1.5. виртуал хөрөнгийн гүйлгээ нь гүйлгээ хийгдсэн хугацаанаас үл хамааран бүртгэлийн системд бүртгэгдсэн хугацаагаар гүйлгээ хийгдсэнд тооцогдох нөхцөл;

9.1.6. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, харилцагчийн эрх, үүрэг;

9.1.7. харилцагчийн анхны шаардлагаар түүний виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарах мөнгөн хөрөнгийг гаргаж өгөх, эсхүл виртуал

хөрөнгийг шилжүүлэх нөхцөл;

9.1.8.виртуал хөрөнгийн талаарх олон улсын хэм хэмжээ, дотоодын хууль тогтоомжоос хамаарч виртуал хөрөнгийн үйлчилгээ болон үнэ цэнэ огцом өөрчлөгдөх эрсдэлийн талаарх мэдээлэл;

9.1.9.виртуал хөрөнгийн гүйлгээ нь буцаах боломжгүй, залилан мэхлэх шинжтэй, эсхүл алдаатай гүйлгээнээс үүдэн гарах үр дагавар, нөхөн төлөгдөхгүй байх эрсдэлийн талаарх мэдээлэл;

9.1.10.виртуал хөрөнгийн үнэ цэнэ нь зах зээлд оролцогчдын эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдох тул үнэ цэнийн хэлбэлзлээс хамаарч алдагдал хүлээх эрсдэлийн талаарх мэдээлэл;

9.1.11.виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ нь залилан мэхлэх болон цахим халдлагад өртөх эрсдэлийн талаарх мэдээлэл;

9.1.12.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид технологийн хүндрэл гарсан тохиолдолд харилцагч өөрийн виртуал хөрөнгийг ашиглах, хэрэглэх боломжгүй болох эрсдэлийн талаарх мэдээлэл;

9.1.13.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн өмчилж, эсхүл эзэмшиж байгаа хөрөнгө нь харилцагчид учирсан хохирлыг бүрэн барагдуулж хүрэлцэхгүй байх эрсдэлийн талаарх мэдээлэл.

9.2.Энэ хуулийн 9.1-д зааснаас бусад гэрээний нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн талууд гэрээнд тусгаж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ, БАРИМТЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, НУУЦЛАЛ

10 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналт тавих

10.1.Энэ хуулийн 6.1-д заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх компани Хороонд хүсэлт гаргаж, бүртгүүлнэ.

10.2.Хороо энэ хуулийн 10.1-д заасан хүсэлт, шаардлага хангасан бүрэн гүйцэд баримт бичгийг хүлээн авснаас хойш зургаан сарын дотор бүртгэх асуудлыг шийдвэрлэнэ.

10.3.Энэ хуулийн 10.2-т заасан хугацааг шаардлагатай тохиолдолд зургаа хүртэл сарын хугацаагаар Хорооны дарга нэг удаа сунгаж болно.

10.4.Хүсэлт гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу бол энэ тухай хүсэлт гаргагчид мэдэгдэх бөгөөд хүсэлт гаргагч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш энэ хуульд заасан баримт бичгийн бүрдлийг хангаж бүртгүүлэх хүсэлтээ ажлын 30 өдрийн дотор дахин гаргаж болно.

10.5.Энэ хуулийн 10.4-т заасан хугацаанд баримт бичгийн бүрдлийг хангаж ирүүлээгүй тохиолдолд хүсэлтийг буцааж, хүсэлт гаргаагүйд тооцно.

10.6.Энэ хуулийн 7.1-д заасан шаардлагыг хангаагүй бол Хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй.

10.7.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн компанийн болон үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл нийтэд нээлттэй ил тод байна. Хороо бүртгэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр мэдээллийг шинэчилнэ.

10.8.Хороо энэ хуулийн 7.1.2, 7.1.5, 7.1.6-д заасан шаардлагыг хангасан эсэх асуудлаар мэргэжлийн холбоогоор дүгнэлт гаргуулж болох бөгөөд дүгнэлт гаргуулахтай холбогдсон зардлыг хүсэлт гаргагч хариуцна.

10.9.Хороо виртуал хөрөнгийн үйлчилгээтэй холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.9.1.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохистой засаглал, үйл ажиллагаа, тайлан мэдээнд тавих шаардлагыг тодорхойлох, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хэмжээг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх, аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох, энэ хуулийн 10.8-д заасан мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журмыг батлах;

10.9.2.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;

10.9.3.энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах;

10.9.4.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулах, чадавхжуулах арга хэмжээ авахыг даалгах;

10.9.5.энэ хуулийн 10.6-д заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтийг бүртгэхээс татгалзах;

10.9.6.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон энэ хуулийн 4.1.4, 7.2-т заасан этгээдээс шаардлагатай баримт, мэдээ, мэдээллийг гаргуулан авах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

10.9.7.шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагатай хамтран энэ хуулийн 10.9.6-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

10.9.8.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох, шийдвэрлүүлэх;

10.9.9.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах;

10.9.10.энэ хуулийн 8.6-д заасан аудитын хуулийн этгээдийг бүртгэх.

10.10.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн гүйлгээ илгээх, хүлээн авах, харилцагч, харилцагчийн хүрээ хязгаар, гүйлгээ хийгдэх гадаад улс, эсхүл тодорхой хуулийн этгээд, гадаад улсаас хөрөнгө оруулалт татах болон бусад үйл ажиллагаанд Хорооноос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор хязгаарлалт тогтоож болно.

10.11.Хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхдээ шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэшсэн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно.

10.12.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч Хорооноос шаардсан бол тодорхой чиглэлээр аудит хийлгэх бөгөөд үүнтэй холбогдсон зардлыг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

10.13.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэснийг тухайн виртуал хөрөнгөд өгч байгаа баталгаа гэж үзэхгүй бөгөөд виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнд үүссэн хохирлыг төр хариуцахгүй.

10.14.Энэ хуулийн 10.9.1-д заасан журмаар Хороо нь өөртөө энэ хуульд зааснаас бусад бүрэн эрх олгохыг хориглоно.

11 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, бүртгэлээс хасах

11.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хууль, эсхүл Хорооноос тогтоосон нэмэлт шаардлагыг хангаж ажиллаагүй бол үйл ажиллагааны онцлог, зөрчлийн шинж байдлыг харгалзан үйл ажиллагааг нь хязгаарлах, түр зогсоох, эсхүл бүртгэлээс хасна.

11.2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүртгэлээс хасагдсан бол энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх эрх дуусгавар болно.

11.3.Хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэлээс хассан бол энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

12 дугаар зүйл.Баримт бичгийн хадгалалт, хамгаалалт

12.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч тухайн үйл ажиллагааны явцад бий болсон цаасан болон цахим баримт бичгийг хүлээн авсан, эсхүл үүсгэсэн өдрөөс хойш 10-аас доошгүй жил хадгалж, хамгаална.

12.2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг баримтална.

13 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал

13.1.Хороо, түүний албан тушаалтан, ажилтан энэ хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэхдээ олж авсан мэдээллийн нууцлалыг доор дурдсанаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно:

13.1.1.энэ хуульд заасан чиг үүргийг гүйцэтгэх;

13.1.2.гэмт хэрэг мөрдөн шалгах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдох байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэх;

13.1.3.тагнуулын байгууллага терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, түүнийг санхүүжүүлэхтэй холбогдох мэдээллийг шалгах;

13.1.4.шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар нотлох баримт, мэдээлэл гаргуулах;

13.1.5.шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

13.1.6.Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүргийг биелүүлэх;

13.1.7.хуульд заасан бусад.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан зохицуулалт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нэгэн адил хамаарна.

14 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс

14.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хуульд заасан улсын тэмдэгтийн хураамж, Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

15 дугаар зүйл.Хамтын ажиллагаа

15.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, түүнд хяналт тавих, шалгалт хийх эрх бүхий байгууллага нь эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд, гадаад улсын ижил чиг үүрэгтэй, нууцлалын байдлаар адил түвшний байгууллага болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллаж болно.

16 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

17 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

17.1.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш дөрвөн сарын хугацаанд аливаа компанийг Хорооноос энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхгүй.

17.2.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлж байсан этгээд энэ хуулийн 17.1-д заасан дөрвөн сарын хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор энэ хуульд заасан шаардлагыг хангаж, Хороонд бүртгүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 99

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, хүний нөөц болон бусад холбогдох зардлыг 2023 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх, шаардлагатай бусад дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо /Н.Учрал/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

“3.1.11. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан үйл ажиллагаа.”

2/6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалт:

“6.1.12. технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор түрших, нэвтрүүлэх сэндбокс зохицуулалтын орчинг бий болгох, холбогдох зохион байгуулалтын нэгж, зөвлөл байгуулах зэрэг харилцааг зохицуулсан Сэндбокс зохицуулалтын журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтран батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих.”

3/6 дугаар зүйлийн 6.2.8 дахь заалт:

“6.2.8. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны чиглэлээр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.2, 27.3 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “эзэмшигч” гэсний дараа “, бүртгэлтэй этгээд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“25.1.8. тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл бүртгэлтэй этгээд хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, эсхүл бүртгэлээс хасах талаар Хороонд санал оруулах;”

4 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын дугаарыг “3.1.12” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын, 24 дүгээр зүйлийн гарчгийн, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.6 дахь заалтын, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “эзэмшигчийн” гэснийг “эзэмшигч, бүртгэлтэй этгээдийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “эзэмшигчид” гэснийг “эзэмшигч, бүртгэлтэй этгээдэд” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын, 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтын, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “эзэмшигчээс” гэснийг “эзэмшигч, бүртгэлтэй этгээдээс” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.1.10 дахь заалтын “эзэмшигчийг” гэснийг “эзэмшигч, бүртгэлтэй этгээдийг” гэж, мөн зүйлийн 6.1.11 дэх заалтын “4.1.8-д” гэснийг “4.1.8, 4.1.10-т” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтын “эзэмшигчдээс” гэснийг “эзэмшигчид, бүртгэлтэй этгээдээс” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.3 дахь хэсэг нэмсүгэй:

“17.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа болон виртуал хөрөнгөтэй холбоотой зар сурталчилгааг захиалах, бүтээх, тоон мэдээ, үзүүлэлтийг ашиглах, түгээхэд дараах зүйлийг хориглоно:

17.3.1.сурталчилж байгаа виртуал хөрөнгөд шууд хамаарахгүй тоон мэдээ, үзүүлэлтийг ашиглах;

17.3.2.нийтэд санал болгох, худалдах виртуал хөрөнгийн талаарх танилцуулга, мэдээлэлд дутуу, худал, төөрөгдүүлсэн мэдээлэл тусгаж нийтэд танилцуулах, эсхүл хязгаарлалт тогтоосон виртуал хөрөнгийг сурталчлах;

17.3.3.виртуал хөрөнгийг эзэмших, арилжаанд оролцсоноор олох ашиг, өгөөжийн талаар таамаглал дэвшүүлэх, амлалт өгөх;

17.3.4.хуульд заасны дагуу виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлээгүй этгээд виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдах тухай сурталчлах;

17.3.5.виртуал хөрөнгийг үнэт цаас, компанийн хувьцаа болон бусад санхүүгийн хэрэгсэл, үйлчилгээтэй адилтган сурталчлах.”

2 дугаар зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн гарчгийн “ажиллагаа,” гэсний дараа “виртуал хөрөнгө,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн Арван наймдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 18.19, 18.20 дугаар зүйл тус тус нэмсүгэй:

“18.19 дүгээр зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээний дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах

1. Виртуал хөрөнгийн үнэ цэнэд нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээллийг ашиглаж виртуал хөрөнгийн арилжаанд оролцсон, эсхүл дотоод мэдээллийг бусдад дамжуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. бүлэглэж;

2.2. албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

18.20 дугаар зүйл. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулан ашиглах

1. Виртуал хөрөнгийн хуурамч арилжаа хийсэн, эсхүл үнэ ханшийг зохиомлоор тогтоосон, эсхүл оролцогч, харилцагчийг арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх зорилгоор хууран мэхэлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан, эсхүл виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эцсийн өмчлөгч, хуулийн этгээдийн хувьцааны тав, түүнээс дээш хувийг эзэмшдэг хүн үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Тайлбар:-Энэ зүйлд заасан “хуурамч арилжаа хийсэн” гэж виртуал хөрөнгийн арилжаанд оролцогч, харилцагчийг төөрөгдүүлэхийн тулд тодорхой виртуал хөрөнгийн өмчлөгч нь өөрчлөгдөөгүй боловч арилжаа идэвхтэй явагдаж байгаа дүр үзүүлэн хэлцэл хийх болон үгсэн хуйвалдах замаар тодорхой виртуал хөрөнгийг худалдах, худалдан авах үнийг ойролцоо түвшинд захиалах, хэлцэл хийхийг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “үнэ ханшийг зохиомлоор тогтоосон” гэж тодорхой виртуал хөрөнгийг бусад этгээд худалдан авах, худалдан авахгүй байх, захиалах, захиалахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ханшийг өсгөх, бууруулах, тодорхой түвшинд барихад чиглэсэн хоёр ба түүнээс дээш хэлцэл хийхийг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “оролцогч, харилцагчийг арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх зорилгоор хууран мэхэлсэн” гэж бодит бус, төөрөгдүүлсэн, эсхүл хуурамч мэдэгдэл, амлалт, таамаг гаргах, нийтлэх, чухал үйл баримтыг нуун дарагдуулах, бодит үйл баримтын талаар худал мэдэгдэл хийх замаар болон тодорхой арга, хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан хэлцлийн нөгөө тал болох этгээдийг төөрөгдүүлэхийг ойлгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “18.6/Мөнгө угаах/ дугаар зүйл,” гэсний дараа “18.19/Виртуал хөрөнгийн үйлчилгээний дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах/ дүгээр зүйл, 18.20/Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулан ашиглах/ дугаар зүйл” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван нэгдүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай 11.33 дугаар зүйл нэмсүгэй:

“11.33 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль зөрчих

1.Виртуал хөрөнгийн үйлчилгээг бүртгэлгүй эрхэлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлийг хурааж, хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн харилцагчийн тухайн үйлчилгээнд хамаарах виртуал хөрөнгийг гүйлгээ хийх, шилжүүлэх, арилжих, хадгалах, удирдах нөхцөл, боломжийг тасралтгүй хангаж ажиллаагүй бол хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон холбогдох этгээд нь хуульд заасан мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, тэдгээрийн хянан шалгагчид саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөөгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Виртуал хөрөнгийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн компаниар дамжуулахгүйгээр нийтэд санал болгож худалдсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлийг хурааж, хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээд нь хуульд заасан шаардлагыг хангаж ажиллаагүй, эсхүл үүргээ хэрэгжүүлээгүй, түүнийг зөрчсөн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.18 дахь заалтын “2, 4, 5 дахь хэсэг”, гэсний дараа “10.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг”, мөн заалтын “11.30,” гэсний дараа “11.33,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.10 дахь заалт нэмсүгэй:

“4.1.10. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч.”

2 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7, 5.12, 5.13 дахь хэсгийн “4.1.7-д” гэснийг “4.1.7, 4.1.10-т” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “болон гадаад төлбөр тооцооны” гэснийг “, гадаад төлбөр тооцоо болон виртуал хөрөнгийн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “4.1.8-д” гэснийг “4.1.8, 4.1.10-т” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.52 дахь заалт:

“5.1.52. Санхүүгийн зохицуулах хороонд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх.”

2/19 дүгээр зүйлийн 19.1.10 дахь заалт:

“19.1.10. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэхээр бүртгэхэд үйл ажиллагаа тус бүр 50 000 000 төгрөг, 6.1.5-д заасан үйл ажиллагааг эрхлэхээр бүртгэхэд 100 000 000 төгрөг.”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 19.1 дэх хэсгийн “олгоход” гэснийг “олгох, бүртгэхэд” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.5.20 дахь заалт нэмсүгэй:

“13.5.20.виртуал хөрөнгийн үйлчилгээ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7 дахь заалтын “сангийн” гэснийг “сан, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.13 дахь хэсэг нэмсүгэй:

“3.13. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан хяналт, шалгалтыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхэд мэргэшсэн этгээдийг оролцуулж, зөвлөх үйлчилгээ авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 57.15, 57.16 дахь хэсэг нэмсүгэй:

“57.15.Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр үр чадвартай хүнийг тухайн чиглэлээр төрийн албанд ажиллуулах шаардлагатай бол албан тушаалын цалингийн итгэлцүүр, шатлалыг Засгийн газар тогтооно.

57.16.Энэ хуулийн 57.15-д заасан цалингийн итгэлцүүр, шатлалыг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, тухайн байгууллагад мэдээлэл технологийн чиглэлээр ажиллах албан тушаалтны орон тооны дээд хязгаарыг Засгийн газар тогтооно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 34.13.4 дэх заалт нэмсүгэй:


“34.13.4.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг тухай бүр.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС
БАТАЛСАН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМУУД**





МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

**“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
бүртгэлийн журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын 1-д заасан журмын гуравдугаар хавсралтын 1-6, 8-11 дэх дугаарт заасан стандартыг 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

*Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн
174 дүгээр тогтоолын хавсралт*

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлэх хүсэлт гаргагч /цаашид “хүсэлт гаргагч” гэх/-ийг бүртгэх, бүртгэхээс татгалзахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Хүсэлт гаргагчийг бүртгэхдээ санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд төрөөс баримталж буй бодлого, харилцагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үйл ажиллагаа ил тод, шударга, тасралтгүй байх зарчмыг баримтална.

Хоёр.Хүсэлт гаргагчид тавигдах шаардлага

2.1.Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан;

2.1.2.Энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

2.1.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан үйлчилгээг эрхлэх хүсэлт гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ тус бүр 400.0 сая төгрөгөөс доошгүй байх;

2.1.4.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 4.1.4, 7.2-т тус тус заасан холбогдох этгээд, эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх.

2.2.Хүсэлт гаргагч энэ журмын 2.1.3-т заасан үйлчилгээг хавсран эрхлэх тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тус бүрээр нэмэгдүүлэн тооцно.

2.3.Хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байна.

Гурав.Бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн шаардлага

3.1.Хүсэлт гаргагч тав буюу түүнээс дээш гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна.

3.2.Энэ журмын 3.1-д заасан төлөөлөн удирдах зөвлөл дараах дүрэм, журам, бодлогын баримт бичгийг баталсан байна:

3.2.1.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

3.2.2.компанийн дөрвөн жилийн бизнес төлөвлөгөө;

3.2.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, дотоод хяналтын хөтөлбөр;

3.2.4.мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;

3.2.5.MNS ISO/IEC 27001 стандартын шаардлага, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлсэн мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам;

3.2.6.дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх журам;

3.2.7.арилжааг үрвүүлэн ашиглахаас сэргийлэх, хяналт тавих журам;

3.2.8.үйл ажиллагааг түр зогсоох, хязгаарлалт тогтоох, татан буугдах, үйлчилгээ зогсох, кибер халдлага, түрэмгийлэлд өртөх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө;

3.2.9.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан тухайн үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааны журам;

3.2.10.бусад шаардлагатай журам.

3.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.2-т заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой журамд өөрийн программ хангамж дээр виртуал хөрөнгийг арилжих, арилжаанаас хасахтай холбогдох зохицуулалтыг тусгасан байна.

3.4.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.5-д заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой журамд дараах зүйлсийг тусгасан байна:

3.4.1.нийтэд санал болгох виртуал хөрөнгө гаргагч болон тухайн виртуал хөрөнгө, түүний танилцуулгад тавигдах шаардлага;

3.4.2.нийтэд санал болгох виртуал хөрөнгө гаргагчийн биелүүлэх үүрэг, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлэх мэдээллийн агуулга, хугацаа;

3.4.3.нийтэд санал болгон гаргасан виртуал хөрөнгийг бүртгэлээс хасах нөхцөл;

3.4.4.бусад.

3.5.Хүсэлт гаргагч дараах бүтэц, зохион байгуулалт, тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцтэй байна:

3.5.1.дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.5.2.мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.5.3.харилцагчийн үйлчилгээний нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.5.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх ба хэрэгжилтэд хяналт тавих этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл байх;

3.5.5.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1-6.1.5-д заасан үйлчилгээг эрхлэхтэй холбоотой үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байна.

3.6.Энэ журмын 3.5-д заасан ажилтан нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шаардлагыг хангасан, хуульд өөрөөр заагаагүй бол давхар ажил хавсран эрхэлдэггүй байна.

3.7.Энэ журмын 3.5.1-3.5.3-д заасан нэгж, эсхүл ажилтны чиг үүргийг гэрээний үндсэн дээр бусад мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Дөрөв.Программ хангамж, мэдээллийн технологид тавигдах шаардлага

4.1.Хүсэлт гаргагч виртуал хөрөнгийн үйлчилгээг үзүүлэхэд шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгай программ хангамжтай байх бөгөөд уг программ хангамж нь дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1.арилжаанд оролцогчид нэгнийгээ таньж мэдэх боломжгүй байх;

4.1.2.харилцагчийн хувийн мэдээлэл гуравдагч этгээдээс нууц байх;

4.1.3.зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, шинэчлэх боломжтой байх;

4.1.4.олон нийтэд мэдээлэл хүргэх хэсэг буюу нээлттэй самбартай байх;

4.1.5.арилжааны хяналтын системтэй байх;

4.1.6.албан ёсны лицензтэй аюулгүй байдлыг хангах системтэй байх.

4.2.Хүсэлт гаргагч энэ журмын гуравдугаар хавсралтад заасан мэдээллийн технологийн стандартын сүүлийн хувилбарыг хангаж, хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.

4.3.Хүсэлт гаргагч гадаад улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, бусад мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийн программ хангамж, үүлэн технологи, эсхүл дата төвийг ашигладаг бол энэ журмын гуравдугаар хавсралтын 11 дэх хэсэг хамаарахгүй бөгөөд энэ талаар холбогдох нотлох баримт бичгийг бүртгүүлэх хүсэлтийн хамт Хороонд ирүүлнэ.

Тав.Бүртгэх, бүртгэхээс татгалзах

5.1.Хүсэлт гаргагч энэ журмын дөрөвдүгээр хавсралтад заасан баримт бичгийг нотлох баримтын хамт Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.2.Хороо хүсэлт гаргагчийн бүртгүүлэх хүсэлтийг Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан хугацаанд хянаж, шийдвэрлэнэ.

5.3.Бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй бол хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэж, нэмэлт баримт бичгийг шаардаж болно.

5.4.Энэ журмын 5.2-т заасан хугацааг зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн баримт бичгийг ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

5.5.Хороо шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичгийн талаар холбогдох этгээдээс тодруулж, дүгнэлт гаргуулж, лавлагаа авч болно.

5.6.Хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа явуулах ажлын байр, тоног төхөөрөмж, программ хангамж нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг Хорооны холбогдох албан тушаалтан газар дээр нь шалгаж, танилцаж болно.

5.7.Хорооноос хүсэлт гаргагчийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэсэн тохиолдолд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

5.8.Хүсэлт гаргагч нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн тохиолдолд компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг хийлгэж, хуулбарыг энэ журмын 5.2-т заасан шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

5.9.Хороо хүсэлт гаргагчийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхээс дараах үндэслэлээр татгалзана:

5.9.1.бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

5.9.2.эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангаагүй;

5.9.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй.

5.10.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10.5-д заасан нөхцөл бий болсон тохиолдолд хүсэлтийг буцааж, хүсэлт гаргаагүйд тооцно.

5.11.Хороо виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид Хорооны даргын албан бичгээр мэдэгдэнэ.

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ын нэгдүгээр хавсралт

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧЭЭР БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хэсэг 1. Эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгоно уу.						
<input type="checkbox"/> Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих <input type="checkbox"/> Нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих <input type="checkbox"/> Виртуал хөрөнгийг шилжүүлэх <input type="checkbox"/> Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах <input type="checkbox"/> Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх						
Хэсэг 2. Хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл						
Ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бэ?						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
Холбоо барих утас						
Цахим шуудангийн хаяг						
Цахим хуудас						

Удирдлага, мэргэшсэн хүний нөөцтэй холбоотой мэдээлэл:						
Нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүд						
Гүйцэтгэх захирал						
Нягтлан бодогч						
Бусад						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ						
Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны төрөл		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь	
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ			
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ			
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ			
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ			
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ			
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>						
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл						
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ	
Программ хангамжийн нэр төрөл	Зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ	

Хэсэг 3. Хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл					
Хувьцаа эзэмшигч аль нь болохыг сонгоно уу.		<input type="checkbox"/> Хуулийн этгээд		<input type="checkbox"/> Иргэн	
1. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.					
Хуулийн этгээдийн нэр					
Улсын бүртгэлийн дугаар					
Регистрийн дугаар					
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр		<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани			
Бизнесийн болон үйл ажиллагааны чиглэл					
Хаяг байршил	Аймаг/хот				
	Сум/дүүрэг				
	Баг/хороо				
	Гудамж, байр				
	Тоот				
	Холбоо барих утас				
Цахим шуудангийн хаяг					
Цахим хуудас					
2. Хувьцаа эзэмшигч нь иргэн бол дараах мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.					
Овог					
Нэр					
Регистрийн дугаар					
Албан ёсны хаяг байршил					
Эрхэлж байгаа ажил, албан тушаал					
Ажлын хаяг					
Эзэмшсэн мэргэжил					
Цахим шуудангийн хаяг					

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэж өгнө үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн хангаж, биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ./:

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:


Хуулийн этгээдийн _____ /_____/
Тэмдэг _____ /гарын үсэг/ _____ /гарын үсгийн тайлал/

*“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
бүртгэлийн журам”-ын хоёрдугаар хавсралт*

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД МЭРГЭШСЭН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийн дугаар:	
Иргэний харьяалал:	
Хүсэлт гаргагчид эрхлэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг:	
Гар утасны дугаар:	
Цахим шуудангийн хаяг:	



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн огноо	Төгссөн огноо	Диплом, гэрчилгээний дугаар

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Шалтгаан

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад мэргэшсэн хүний нөөцийн холбогдох этгээдийн байдал

№	Таны хэн болох	Овог, нэр / Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

/Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл/

Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна.

Тодорхойлолт гаргасан:

/_____ / /_____ / _____ /_____ /_____ /
 /овог, нэр/ /гарын үсэг/ /огноо/

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ын гуравдугаар хавсралт

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТЫН ЖАГСААЛТ

№	Стандартын нэр	
1	MNS 5969	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага
2	MNS 25030	Программ хангамжийн боловсруулалт-Программ хангамжийн бүтээгдэхүүний чанарын шаардлага болон үнэлгээ (Square)-чанарын шаардлагууд
3	MNS 6197	Мэдээллийн технологи-Мэдээллийн аюулгүй байдал-Криптографийг хэрэгжүүлэх удирдамж
4	MNS 6242-2	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-2-р хэсэг: Сүлжээний аюулгүй байдлын архитектур
5	MNS ISO 12207	Программ хангамж боловсруулах үйл ажиллагааны циклүүд
6	MNS ISO 10011-1	Системийн чанарын шалгалтын удирдамжууд
7	MNS ISO/IEC 27001	Мэдээллийн технологи: Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-Шаардлага
8	MNS ISO/IEC 13335-1	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн ба холбооны технологийн байдлын удирдлага-1-р хэсэг: Мэдээлэл холбооны технологийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд болон загварууд
9	IEEE 829	Программ хангамж турших болон баримт бичигжүүлэлтийн стандарт
10	MNS 6498	Харилцаа холбооны тоног төхөөрөмжид тавих аюулгүй байдлын шаардлага
11	MNS 6528	Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц

*Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
бүртгэлийн журам"-ын дөрөвдүгээр хавсралт*

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙГ БҮРТГЭХЭД
ИРҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын нэгдүгээр хавсралт дахь өргөдөл	
2	Улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	
3	Виртуал хөрөнгийн үйлчилгээнд ашиглах программ хангамжийн танилцуулга, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангасан талаарх мэдээлэл, мэдээлэл хадгалах системийн талаар танилцуулга	
4	Тухайн үйл ажиллагааны дөрвөн жилийн бизнес төлөвлөгөө	
5	Компанийн дотоод бүтэц, зохион байгуулалт, мэргэшсэн хүний нөөцийн талаар энэ журмын хоёрдугаар хавсралт дахь тодорхойлолт болон холбогдох баримт бичиг	
6	Хүсэлт гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт	
7	Харилцагчийн мөнгөн хөрөнгийг өөрийн компанийн данснаас тусад нь зөвхөн харилцагчид үйлчилгээ үзүүлэхэд ашиглах зорилгоор банканд тусгайлан нээсэн дансны талаарх мэдээлэл, банктай байгуулсан гэрээ	
8	Хороонд хүсэлт гаргахаас өмнөх хугацаанд үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийн хувьд сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, дүгнэлт, шинээр үүсгэн байгуулсан бол эхлэлтийн баланс	
9	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системийн талаарх танилцуулга	

10	Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологитой холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ	
11	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар авах арга хэмжээний төлөвлөгөө	
12	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр	
13	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7.1.11, 7.1.12, 7.1.13-т тус тус заасан шаардлагыг хангасан тухай татварын албаны тодорхойлолт	
14	Улсын тэмдэгтийн хураамж, Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт	
15	Хүсэлт гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээдийн энэ журмын хоёрдугаар хавсралт дахь тодорхойлолт болон Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан тохиромжтой этгээдийн шалгуур хангасныг нотлох баримт бичиг	
16	Энэ журмын 3.2-т заасан журмууд, төлөвлөгөө	
17	Харилцагчдад үзүүлэх үйлчилгээний төрөл, тэдгээрээс авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ, харилцагчтай байгуулах гэрээний төсөл	
18	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд харьяалах, эсхүл бусад улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт	
19	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд харьяалах, эсхүл бусад улс, оронд гааль, татварын өртэй эсэхийг харуулсан баримт бичиг	
20	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтан нь харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт	
21	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтан нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдож байгаагүй болохыг нотлох баримт	
22	Компанийн ажлын байрны тодорхойлолт, ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийн байр бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

**“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
үйл ажиллагааны журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын 3.2-3.10 дахь заалтыг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

*Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн
175 дугаар тогтоолын хавсралт*

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч /цаашид “ВХҮҮ” гэх/-ийн зохистой засаглал, үйл ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээ, тайлан мэдээнд тавигдах шаардлагыг тодорхойлохтой холбогдох харилцааг зохицуулна.

1.2.ВХҮҮ нь Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” болон түүнд нийцүүлсэн дүрэм, журам, заавар аргачлалыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

1.3.ВХҮҮ харилцагчийн эрх ашгийг хамгаалж, виртуал хөрөнгийн зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжиж ажиллана.

Хоёр.Виртуал хөрөнгийг арилжих үйл ажиллагаа

2.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

2.2.ВХҮҮ харилцагчийн захиалгын үнэ ханш, цаг хугацааны дарааллын дагуу арилжааг шударгаар зохион байгуулна.

2.3.ВХҮҮ харилцагчийг арилжааны талаарх мэдээлэлтэй тухай бүр танилцах боломжоор хангасан байна.

2.4.ВХҮҮ дотоод мэдээллийг хууль бусаар болон арилжааг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах захиалга, арилжаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол хэрэгжүүлнэ:

2.4.1.өндөр үнийн дүнтэй;

2.4.2.үнэ ханшийн өсөлт, бууралт ихтэй;

2.4.3.үнэ ханшид нөлөөлөхүйц үнээр, цөөн тоо ширхгээр арилжсан;

2.4.4.холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хооронд 5 ба түүнээс дээш удаа арилжаа хийгдсэн;

2.4.5.хэвийн бус, анхаарал татсан гэж үзсэн бусад.

2.5.ВХҮҮ энэ журмын 2.4-д заасан захиалга, арилжаанд хийсэн хяналт, шалгалтаар Эрүүгийн хуулийн 18.19, 18.20 дугаар зүйлд тус тус заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болзошгүй гэж сэжиглэсэн тохиолдолд 24 цагийн дотор мэдээллийг нотлох баримтын хамт Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлж, Хороонд мэдээлнэ.

2.6.Виртуал хөрөнгийн арилжааны хэлцэл биелсний дараа дор дурдсан мэдээллийг харилцагч авах боломжтой байна:

- 2.6.1.виртуал хөрөнгийн нэр;
- 2.6.2.хэлцэл биелсэн хугацаа;
- 2.6.3.арилжсан виртуал хөрөнгийн хэмжээ, үнэ ханш;
- 2.6.4.бусад шаардлагатай мэдээлэл.

2.7.ВХҮҮ арилжааг дараах аргаар зохион байгуулах боломжтой байна:

- 2.7.1.зах зээлийн үнийн арга (market order);
- 2.7.2.нөхцөлт захиалгын арга (limit order).

2.8.ВХҮҮ арилжаанаас хассан виртуал хөрөнгийн мэдээллийг тайлбарын хамт 24 цагийн дотор Хороонд албан бичгээр хүргүүлнэ.

Гурав.Виртуал хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагаа

3.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.3-д заасан үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

3.2.Шилжүүлэгч ВХҮҮ нь гурван сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгийг шилжүүлэхэд дараах мэдээллийг хүлээн авагч ВХҮҮ-д хүргүүлсэн байна:

- 3.2.1.шилжүүлэгчийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр;
- 3.2.2.шилжүүлэгчийн регистрийн дугаар;
- 3.2.3.шилжүүлгийн дугаар, эсхүл шилжүүлэгчийн хэтэвчний хаяг;
- 3.2.4.шилжүүлэгчийн бүртгэлтэй хаяг;
- 3.2.5.шилжүүлгийн зорилго;
- 3.2.6.хүлээн авагчийн овог, нэр /хуулийн этгээдийн нэр;
- 3.2.7.хүлээн авагчийн бүртгэлтэй хаяг;
- 3.2.8.хүлээн авагч талын улсын нэр;
- 3.2.9.хүлээн авагч талын ВХҮҮ-ийн нэр;

3.2.10.шаардлагатай бусад.

3.3.Хүлээн авагч ВХҮҮ нь гурван сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй виртуал хөрөнгийг хүлээн авахдаа шилжүүлэгч ВХҮҮ-ээс дараах мэдээллийг авсан байна:

3.3.1.шилжүүлэгчийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр;

3.3.2.шилжүүлэгчийн регистрийн дугаар;

3.3.3.шилжүүлгийн дугаар, эсхүл шилжүүлэгчийн хэтэвчний хаяг;

3.3.4.шилжүүлэгчийн бүртгэлтэй хаяг;

3.3.5.хүлээн авагчийн овог, нэр;

3.3.6.шилжүүлгийн дугаар, эсхүл хүлээн авагчийн хэтэвчний хаяг.

3.4.ВХҮҮ бүртгэлгүй хэтэвчнээс шилжүүлэг хүлээн авах тохиолдолд энэ журмын 3.3-т заасан мэдээллийг авсан байна.

3.5.Шилжүүлэгч ВХҮҮ энэ журмын 3.3-т заасан мэдээллийг нэн даруй буюу шилжүүлэг хийхээс өмнө, эсхүл шилжүүлэг хийгдэх хугацаанд, аюулгүй хэлбэрээр хүргүүлсэн байна.

3.6.Шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ нь энэ журмын 3.2, 3.3-т заасан мэдээллийг дамжуулах, хүлээн авахаас өмнө хамтрагч ВХҮҮ-ийг тодорхойлж, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан эсэхийг үнэлсний үндсэн дээр шилжүүлгийг хийнэ.

3.7.Шилжүүлэгч ВХҮҮ дундын ВХҮҮ-ээр дамжуулан шилжүүлгийг хийсэн тохиолдолд энэ журмын 3.2, 3.3-т заасныг хэрэгжүүлнэ.

3.8.Шилжүүлэгч ВХҮҮ нь шилжүүлэг хийж байгаа харилцагчийн мэдээлэл, хүлээн авагч ВХҮҮ нь хүлээн авч буй харилцагчийн мэдээллийн үнэн бодит байдлыг шалгасан байна.

3.9.ВХҮҮ харилцагчийг таньж мэдэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлж, өндөр эрсдэлтэй гэж үзсэн этгээдрүү шилжүүлэг хийхгүй болон түүнтэй бизнесийн харилцаа тогтоохгүй.

3.10.Шилжүүлэгч болон хүлээн авагч ВХҮҮ нь энэ журмын 3.2, 3.3-т заасан мэдээллийг эрх бүхий байгууллагад түргэн шуурхай гаргаж өгөхөд бэлэн хадгална.

3.11.ВХҮҮ харилцагчийн виртуал хөрөнгийг шилжүүлэхдээ багадаа хоёр шатлалт танилт хийж, IP хаяг, хэтэвчний хаягийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулна.

Дөрөв.Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах

4.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

4.2.ВХҮҮ өөрийн хөрөнгийг 100 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй харилцагчийн виртуал хөрөнгийг хадгалж, удирдана.

4.3.ВХҮҮ өөрийн хөрөнгийн хэмжээний шалгуурыг улирал бүр тооцож, энэ журмын 4.2-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

4.4.ВХҮҮ виртуал хөрөнгийг харилцагчийн даалгавраар хадгалах, удирдахдаа багадаа хоёр шатлалт танилт хийж, IP хаяг, хэтэвчний хаягийн үнэн зөв, бодит байдлыг баталгаажуулна.

Тав.Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх

5.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.5-д заасан үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

5.2.ВХҮҮ виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажлыг зохион байгуулахаас өмнө тухайн виртуал хөрөнгө гаргагчтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна.

5.3.ВХҮҮ виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажлыг зохион байгуулахаас өмнө дараах мэдээлэлд үндэслэж шийдвэр гаргасан байна:

5.3.1.виртуал хөрөнгө, түүний төсөл нь эдийн засгийн үр ашигтай, бодитой, хэрэгжихүйц эсэх;

5.3.2.виртуал хөрөнгө гаргагч, түүний эцсийн өмчлөгч, эрх бүхий албан тушаалтан нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хугацаа хэтэрсэн өр зээлгүй, бизнесийн нэр хүндтэй, мэргэжлийн багтай эсэх;

5.3.3.виртуал хөрөнгийн суурилсан блокчэйн нь бүрэн хөгжүүлэлт хийгдэж, кибер аюулгүй байдлыг хангасан эсэх;

5.3.4.бусад.

5.4.ВХҮҮ виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдах танилцуулгад дор дурдсан мэдээллийг тусгуулсан байна:

5.4.1.танилцуулга нь монгол хэл дээр бичигдсэн байх;

5.4.2.виртуал хөрөнгийн хэрэглээ, гаргаж буй зорилго, блокчэйний төрөл;

5.4.3.виртуал хөрөнгө гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны талаар;

5.4.4.виртуал хөрөнгө гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ;

5.4.5.виртуал хөрөнгө гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны нэр, зураг, ажлын туршлага, бусад нэмэлт мэдээлэл;

5.4.6.виртуал хөрөнгө гаргагчийн сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;

5.4.7.нийтэд санал болгох виртуал хөрөнгийн тоо хэмжээ, санал болгох үнэ;

5.4.8.татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө;

5.4.9.виртуал хөрөнгийн хуваарилалт, тархалтын мэдээлэл;

5.4.10.виртуал хөрөнгө гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн талаарх мэдээлэл;

5.4.11.виртуал хөрөнгөнд хийсэн технологийн аудитын дүгнэлт;

5.4.12.шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

5.5.ВХҮҮ виртуал хөрөнгийн танилцуулга, холбогдох баримт, мэдээллийг нийтэд санал болгох, худалдах ажиллагааг зохион байгуулахаас өмнө ажлын 10 өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

5.6.ВХҮҮ виртуал хөрөнгийн танилцуулга, токеномикс, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зургаа.Мэдээллийн ил тод байдал, харилцагчийн эрх ашгийг хамгаалах

6.1.ВХҮҮ дараах мэдээллийг өөрийн программ хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр байршуулна:

6.1.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 9.1.1-9.1.13, 10.13-д заасан мэдээлэл;

6.1.2.арилжааны программ хангамжийг ашиглахтай холбоотой заавар, зөвлөмж, гарын авлага;

6.1.3. олон нийттэй харилцах утас, цахим шуудан, олон нийтийн сүлжээний хаяг, үйл ажиллагаа явуулж буй хаяг байршил;

6.1.4. өөрийн программ хангамжаар дамжуулан арилжиж буй дотоодын нийтэд санал болгон, худалдсан виртуал хөрөнгийн танилцуулга;

6.1.5. бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;

6.1.6. виртуал хөрөнгийн блокчэйн дээрх бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг, нийт гаргасан болон арилжиж буй тоо ширхэг, үнэлгээ, ханш, арилжааны дүн;

6.1.7. виртуал хөрөнгийн бүртгэлийн шаардлага, шалгуур, дүрэм, журам;

6.1.8. харилцагчийн санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл;

6.1.9. ВХҮҮ-ийн үндсэн үйл ажиллагааны танилцуулга, санхүүгийн тайлан, бизнест шүүд нөлөө үзүүлэхүйц хэлцлийн талаар;

6.1.10. үйл ажиллагаанд ашиглах программ хангамж, систем болон мэдээлэл, технологийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаар.

6.2. ВХҮҮ өөрийн программ хангамжаар дамжуулан нийтэд санал болгон, худалдсан виртуал хөрөнгө гаргагчийн үйл ажиллагааны дараах өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр мэдээлнэ:

6.2.1. эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт;

6.2.2. виртуал хөрөнгийн танилцуулга, токеномикс, үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрчлөлт, тэдгээрийн гүйцэтгэл буурсан;

6.2.3. бүтэц, зохион байгуулалтад орсон өөрчлөлт;

6.2.4. эрх бүхий албан тушаалтан, ажилтан эдийн засгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүхээр тогтоогдсон;

6.2.5. ВХҮҮ-ийн үйл ажиллагааны дотоод журамд заасан бусад мэдээлэл.

6.3. ВХҮҮ харилцагчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.3.1. харилцагчийн өргөдөл, гомдлын бүртгэл хөтөлж, хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор хариу хүргүүлэх;

6.3.2. харилцагч, олон нийтийн виртуал хөрөнгийн эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг улирал бүр зохион байгуулах;

6.3.3.өөрийн ажилтнаас харилцагчийн хувийн мэдээллийг гадагш задруулахгүй, ажлын шаардлагаас бусад зорилгоор ашиглахгүй байх талаар баталгааг авах.

6.4. ВХҮҮ виртуал хөрөнгийн арилжааг урвуулан ашиглахаас сэргийлэх зорилгоор дараах мэдээллийг тогтмол, эсхүл тухай бүр программ хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр урьдчилан байршуулж, олон нийтэд мэдээлнэ:

6.4.1. арилжааны программ хангамж дахь виртуал хөрөнгийн үнэ ханш нь олон улсын зах зээл дээрх дундаж үнээс харьцангуй доогуур, эсхүл дээгүүр байх тохиолдолд үнийн зөрүүг тогтворжуулан хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хийж буй тухайн ВХҮҮ-ийн арилжааны талаар;

6.4.2. виртуал хөрөнгө гаргагч нь тухайн виртуал хөрөнгийн үнэ ханшийг огцом унахаас сэргийлэх зорилгоор ВХҮҮ-тэй тохиролцож, холбогдох гэрээ байгуулсны үндсэн дээр өөрөө эргүүлэн худалдан авах ажиллагааны талаар.

Долоо.Мэдээлэл, тайлагнал

7.1. ВХҮҮ хууль тогтоомж, энэ журамд заасан мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүйгээр тогтоосон хугацаа болон тухай бүрд харилцагч, олон нийтэд мэдээлж, Хороонд хүргүүлж тайлагнана.

7.2. ВХҮҮ жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор, хагас жил, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлнэ.

7.3. ВХҮҮ аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийг дараа оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

7.4. ВХҮҮ дараах мэдээллийг агуулсан үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ:

7.4.1. тайлант жилд ВХҮҮ-ийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлс;

7.4.2. санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах болон шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх;

7.4.3. бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлт;

7.4.4.хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт;

7.4.5.ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;

7.4.6.сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, тухайн хэлцэлд оролцогч талууд;

7.4.7.эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын ажлын тайлан;

7.4.8.бусад мэдээлэл.

7.5.ВХҮҮ оноосон нэр, хаяг байршил болон холбогдох этгээдээс бусад хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 5 өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

7.6.ВХҮҮ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг урьдчилан энэхүү журмын нэгдүгээр болон хоёрдугаар хавсралтын дагуу баримт бичгийг бүрдүүлж, Хороонд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

7.7.Хороо энэхүү журмын 7.6-д заасан хүсэлтийг зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн баримт бичгийг ирүүлснээс хойш ажлын 10 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын нэгдүгээр хавсралт

ВХҮҮ-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах тухай өргөдөлд хавсаргах баримт бичиг

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын хоёрдугаар хавсралт дахь өргөдөл	
2	Өөрчлөлт оруулах эрх зүйн үндэслэл болсон нотлох баримт бичиг, шийдвэр	
3	Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуур хангасныг тодорхойлох баримт бичиг	
4	ВХҮҮ-ийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл, түүнийг нотлох баримт	
5	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан зохицуулалттай этгээдийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл	

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын хоёрдугаар хавсралт

ВХҮҮ-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах тухай өргөдөл

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр		
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр							
Улсын бүртгэлийн дугаар							
Регистрийн дугаар							
Дараах төрлөөс сонгоно уу.							
<input type="checkbox"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах <input type="checkbox"/> Холбогдох этгээдэд өөрчлөлт оруулах <input type="checkbox"/> Эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах							
Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгө /ХНХ/-ийн хэмжээнд өөрчлөлт оруулах							
Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ-ийн хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь	
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)							
Хэсэг 2. Холбогдох этгээдэд өөрчлөлт оруулах							
Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр	Эцсийн өмчлөгч эсэх	ХНХ-ийн 5, түүнээс дээш хувийг эзэмшдэг эсэх	Харьяалал	Регистрийн дугаар	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь
Хэсэг 3. Эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах							
Албан тушаал	Овог нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Мэргэжил	Утасны дугаар		

Өргөдөл гаргасан:

_____ (Эрх бүхий албан тушаалтан)

_____ (гарын үсэг)

_____ (огноо)



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

**“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг
бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг
тогтоох журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын 1-д заасан журмын 2.1.6 дахь заалтыг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

*Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн
176 дугаар тогтоолын хавсралт*

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭХЭД ТАВИХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээд /цаашид “аудитын хуулийн этгээд” гэх/-ийг бүртгэх, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбогдох харилцааг зохицуулна.

Хоёр.Аудитын хуулийн этгээдэд тавигдах нөхцөл, шаардлага

2.1.Аудитын хуулийн этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, аудитын үйл ажиллагааг хоёроос доошгүй жил эрхэлсэн байх;

2.1.2.дөрвөөс дээш орон тооны аудитортой байх;

2.1.3.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30.0 сая төгрөгөөс дээш байх;

2.1.4.аудитор нь мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээг байгуулсан байх;

2.1.5.аудитор нь мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх;

2.1.6.аудитор нь Хороо болон Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10.8-д заасан мэргэжлийн холбооноос хамтран зохион байгуулсан багц сургалтад хамрагдсан байна.

Гурав.Аудитын хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичиг

3.1.Энэ журмын 2-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан аудитын хуулийн этгээд нь бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр Хороонд ирүүлнэ:

3.1.1.энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан бүртгүүлэхийг хүссэн өргөдөл;

3.1.2.энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан холбогдох баримт бичгүүд.

3.2.Аудитын хуулийн этгээд бүртгэлээс хасуулах хүсэлт болон оноосон нэр, хаяг байршил, гүйцэтгэх захирал, аудитор өөрчлөгдсөн мэдээллийг тухай бүр энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан өргөдлийг хоёрдугаар хавсралтад заасан холбогдох баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ.

Дөрөв.Аудитын хуулийн этгээдийн бүртгэл, бүртгэлийн хугацаа, мэдээлэл

4.1.Хороо энэ журмын 2-т заасан нөхцөл, шаардлага болон хоёрдугаар хавсралтад заасан холбогдох баримт бичгийн бүрдэл хангасан гэж үзвэл ажлын 15 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

4.2.Аудитын хуулийн этгээдийн бүртгэлийн хүчинтэй хугацаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн аудитын хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна.

4.3.Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан аудитын байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

4.4.Хороонд бүртгэгдсэн аудитын хуулийн этгээдийг дараах үндэслэлээр бүртгэлээс хасна:

4.4.1.өөрийн хүсэлтээр;

4.4.2.Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй;

4.4.3.бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.4.4.холбогдох хууль тогтоомж болон энэ журмын нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон;

4.4.5.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн нууцтай холбогдсон мэдээллийг бусдад задруулсан, дамжуулсан нь тогтоогдсон;

4.4.6.хуурамч дүгнэлт гаргасан;

4.4.7.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

4.5.Энэ журмын 4.4.1-т зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан аудитын хуулийн этгээд нь бүртгэлээс хасагдсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд Хороонд дахин бүртгүүлэхээр хандах эрхгүй.

4.6.Хороо аудитын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд аудитын чанарын хяналт шалгалтыг дангаар, эсхүл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтарч хийж болно.

4.7.Аудитын хуулийн этгээдийг бүртгэсэн, эсхүл бүртгэлээс хассан тохиолдолд ажлын 5 өдөрт багтаан тухайн хуулийн этгээдэд болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр мэдэгдэж, Хорооны цахим хуудсанд байршуулна.

---oOo---

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ын нэгдүгээр хавсралт

АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он	Сар	Өдөр
Хуулийн этгээдийн мэдээлэл			
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр			
Үйл ажиллагааны чиглэл/ ангилал			
Регистрийн дугаар			
Улсын бүртгэлийн дугаар			
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ			
Тусгай зөвшөөрлийн дугаар			
Сангийн сайдын тушаалын огноо, дугаар/ тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа			
Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа			
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ / төгрөгөөр/			
Тэмдэглэл: тохирохыг сонгож тохирох нүдэнд “√” тэмдэглэгээ тавих			
<input type="checkbox"/> Бүртгэл хийлгэх <input type="checkbox"/> Бүртгэлээс хасуулах <input type="checkbox"/> Оноосон нэр өөрчилсөн мэдээлэл		<input type="checkbox"/> Хаяг байршил өөрчилсөн мэдээлэл <input type="checkbox"/> Аудитор өөрчилсөн мэдээлэл <input type="checkbox"/> Гүйцэтгэх удирдлага өөрчилсөн мэдээлэл	
Холбоо барих утас	Суурин	Гар утас	Факс
Цахим шуудангийн хаяг			
Цахим хуудас			
Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл			
Хуулийн этгээдийн хаяг байршил	Аймаг/ хот		
	Сум/дүүрэг		
	Баг/хороо		
	Гудамж, байр		
	Тоот		
<input type="checkbox"/> Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээсэлсэн <input type="checkbox"/> Бусад			
<i>/тохирохыг сонгож “√” тэмдэглэгээ хийнэ./</i>			
Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байх.			

Хувьцаа эзэмшигч					
№	Овог, нэр/хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөг)	
Тэмдэглэл: Хүн тус бүрийг жагсаан бичих					
Удирдах зөвлөлийн дарга, гишүүн					
№	Овог, нэр	Регистрийн дугаар	Дарга/ гишүүн	Оршин суух хаяг, холбоо барих утас	
Тэмдэглэл: Хүн тус бүрийг жагсаан бичих					
Гүйцэтгэх захирал					
№	Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас		
<i>Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь хуулийн этгээдийг удирдахад харшлахгүй, хуулийн этгээдийн үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршлагатай, ашиг сонирхлыг хувийн ашгаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж, тохиромжтой этгээдийн шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.</i>					
Аудиторын тоо		Үндсэн	Туслах	Гэрээт /Бусад ажилтан/	
Овог, нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас	Тухайн хуулийн этгээдэд ажил үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн дугаар, хугацаа	ММНББИ-ийн батламжийн дугаар	Төрөлжсөн сургалтын нэр, огноо, гэрчилгээний дугаар
1.					
2.					
3.					
4.					
5.					
Өөрчлөлтийн мэдээлэл /Энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан холбогдох баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ/					
1. Оноосон нэр өөрчилсөн мэдээлэл					
Оноосон нэр өөрчлөх шийдвэрийн огноо, дугаар					
Хуулийн этгээдийн шинэ нэр (Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас авсан шинэ нэрийн баталгаажуулалтын хуудаст тусгагдсан нэрийг бичих)					
Тэмдэглэл: Шинэ нэрийг бүртгэсэн Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар хавсаргах					

2. Аудитор өөрчилсөн мэдээлэл

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Эрх олгосон огноо, шийдвэрийн дугаар	Тухайн хуулийн этгээдэд ажил үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн дугаар, хугацаа	ММНББИ-ийн батламжийн дугаар	Төрөлжсөн сургалтын нэр, огноо, гэрчилгээний дугаар
1						
2						
3						
4						

Тэмдэглэл: өөрчлөгдсөн хүн бүрийг жагсаах

3. Гүйцэтгэх захирал өөрчилсөн мэдээлэл

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Албан тушаалд томилогдсон огноо	Оршин суух хаяг, холбоо барих утас	Өмнө хаана ажиллаж байсан	Ажлаас гарах болсон шалтгаан

Тэмдэглэл: гүйцэтгэх захирлыг бүртгэсэн Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар хавсаргах

4. Шинэ хаяг байршлын өөрчлөлтийн мэдээлэл

Хуулийн этгээдийн дүрэмд шинэ хаяг байршлыг тусгах шийдвэрийн огноо, дугаар		_____ он _____ сар _____ өдөр	дугаар _____
Хаяг байршил	Аймаг/ хот		
	Сум/дүүрэг		
	Баг/хороо		
	Гудамж, байр		
	Тоот		
	Холбоо барих утас		

Тэмдэглэл: Шинэ хаяг байршил тусгагдсан дүрмийн хуулбар хавсаргах.

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв үг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдээр бүртгэнэ үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, стандарт, журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ./:

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Хуулийн этгээдийн _____ /_____/
 Тэмдэг _____ /гарын үсэг/ _____ /гарын үсгийн тайлал/

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-ын хоёрдугаар хавсралт

ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
Нийтлэг		
1	Бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /энэ журмын нэгдүгээр хавсралт/, албан бичиг	
Аудитын хуулийн этгээдийг бүртгүүлэх		
1	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	
2	Компанийн танилцуулга болон дүрмийн хуулбар	
3	Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар	
4	Аудитын тухай хууль болон Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шаардлагыг тухайн жил хангаж ажилласан талаар ММНБИ-д батлагдсан загварын дагуу тайлагнадаг тухай тодорхойлолт	
5	Аудиторууд нь ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, эсхүл зөрчилгүйд тооцогдох хугацаа нь дууссан эсэх талаар ММНБИ-ийн тодорхойлолт	
6	Аудитын хуулийн этгээдийн аудитын үйл ажиллагааны горим, дотоод хяналтын журмын баталгаажсан хуулбар	
7	Хувьцаа эзэмшигчдийн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх тухай шийдвэр	
8	Өргөдөл гаргах үеийн санхүүгийн тайлан	
Өөрийн хүсэлтээр бүртгэлээс хасуулах		
1	Бүртгэлээс хасуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн хуулбар	
2	Өргөдөл гаргах үеийн санхүүгийн тайлан	
Оноосон нэр өөрчлөлтийн мэдээлэл		
1	Өөрчлөлт орсон дүрмийн баталгаажуулсан хуулбар	
2	Өөрчлөлт орсон Улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын баталгаажуулсан хуулбар	
Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийн мэдээлэл		
1	Гүйцэтгэх захирлыг томилсон шийдвэрийн хуулбар	
2	Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг бүртгэсэн Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар	
Аудиторын өөрчлөлтийн мэдээлэл		
1	Аудит ба баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламжийн хуулбар	

2	Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний хуулбар	
3	Аудитор нь ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, эсхүл зөрчилгүйд тооцогдох хугацаа нь дууссан эсэх талаар ММНБИ-ээс гаргасан тодорхойлолт	
4	Виртуал хөрөнгийн багц сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар	
Хаяг байршлын өөрчлөлтийн мэдээлэл		
1	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн өөрчлөгдсөн хаяг, байршилтай тухайн хуулийн этгээдийн дүрмийн баталгаажсан хуулбар	
2	Хаяг байршил бүртгэсэн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

**“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг
тогтоох журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын 1-д заасан журмыг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

*Санхүүгийн зохицуулах хорооны
2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн
177 дугаар тогтоолын хавсралт*

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНД ТАВИХ ШААРДЛАГЫГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоо /цаашид “Мэргэжлийн холбоо” гэх/-нд тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2.Мэргэжлийн холбоог энэ журамд тавигдсан шаардлагыг хангасан эсэхийг Хорооны хуралдаанаар тодорхойлж, санамж бичиг байгуулан хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.
- 1.3.Мэргэжлийн холбоо нь гишүүдийн тоонд орсон өөрчлөлтийн мэдээг бүтэн жилээр Хороонд ирүүлнэ.

Хоёр.Мэргэжлийн холбоонд тавигдах шаардлага

- 2.1.Мэргэжлийн холбоо дараах шаардлагыг хангасан байна:
 - 2.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх;
 - 2.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй Хороонд бүртгэлтэй Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;
 - 2.1.3.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 7.1.2, 7.1.5, 7.1.6-д заасан шаардлагыг хангасан талаар дүгнэлт гаргах мэргэжлийн чадамжтай байх;
 - 2.1.4.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй, гишүүддээ мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чадамжтай байх;
 - 2.1.5.мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын бүтэцтэй байх.
- 2.2.Мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуурыг хангасан байна.

2.3. Мэргэжлийн холбооны хаяг байршил, удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал өөрчлөгдөх тухай бүр энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ.

2.4. Мэргэжлийн холбоо сургалтын хөтөлбөр боловсруулж, Хороогоор батлуулна.

Гурав. Бүрдүүлэх баримт бичиг

3.1. Мэргэжлийн холбоо энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан хамтран ажиллах санамж бичиг байгуулах хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ.

3.2. Мэргэжлийн холбооны бүх гишүүдийн хурлаар баталсан Мэргэжлийн холбооны дүрэм болон холбогдох бусад дүрэм, журам нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон Хорооны холбогдох журамд нийцсэн байна.

3.3. Хороо энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг бүрэн гүйцэд хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор хянаж, хамтран ажиллах санамж бичиг байгуулах эсэх тухай хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

Дөрөв. Мэргэжлийн холбооны үйл ажиллагааны зарчим

4.1. Мэргэжлийн холбоо дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

4.1.1. хууль тогтоомж, Хорооноос баталсан журмыг мөрдөх;

4.1.2. гишүүдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдгээрийн санал санаачилгыг дэмжих;

4.1.3. гишүүнчлэлийн хураамжийн зарцуулалт, тайлагнал ил тод, нээлттэй байх;

4.1.4. гишүүдийн мэдээллийн нууцыг хадгалах;

4.1.5. виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зах зээлийн нөхцөл байдал, гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө судалгаа шинжилгээнд суурилсан байх.

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын нэгдүгээр хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛАХ ХҮСЭЛТ

Хүсэлт гаргасан огноо	Он	Сар	Өдөр		
Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан эсэх			<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Тийм бол хаана, ямар үйл ажиллагааг, хэдий хугацаагаар эрхэлсэн талаар бичих					
Өмнө нь хүсэлт ирүүлж байсан эсэх			<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
Тийм бол хэзээ ирүүлсэн, хэрхэн шийдвэрлэсэн талаар бичих					
I. Мэргэжлийн холбооны ерөнхий мэдээлэл					
Хүсэлт гаргасан Мэргэжлийн холбооны нэр			Монгол		
			Англи <i>(Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)</i>		
Оноосон нэр өөрчлөлт орсон			Нэр _____		
			Хэзээнээс ____/____/____ хүртэл ____/____/____ <i>(Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл ашиглагдсан талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)</i>		
Үүсгэн байгуулагдсан огноо			____/____/____	____/____/____	____/____/____
			<i>(Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан хурлын огноог бичих)</i>		
Улсын бүртгэлийн дугаар					
Регистрийн дугаар					
Холбоо барих утас			Суурин:	Гар утас:	Факс:
Цахим шуудангийн хаяг					
Цахим хуудас					
II. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл					
<input type="checkbox"/> Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээсэлсэн <input type="checkbox"/> Бусад <i>/тохирохыг сонгож “√” тэмдэглэгээ тавих/</i>					
Хаяг байршил			Аймаг/ хот		
			Сүм/дүүрэг		
			Баг/хороо		
			Гудамж, байр		
			Тоот		

Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байх.

III. Мэргэжлийн холбооны гишүүдийн мэдээлэл

№	Гишүүн хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Оршин суух хаяг, холбоо барих утас

Тэмдэглэл: Гишүүн тус бүрийг жагсаан бичих.

IV. Мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн дарга, гишүүн болон гүйцэтгэх захирал

а/ Удирдах зөвлөлийн дарга, гишүүн

№	Овог, нэр	Дарга / гишүүн

Тэмдэглэл: Удирдах зөвлөлийн гишүүн бүрийг жагсаах ба энэ журмын гуравдугаар хавсралтад заасны дагуу мэдээллийг бичиж холбогдох баримт бичгийг хавсаргах.

□ Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь мэргэжлийн холбоог удирдахад харшлахгүй, мэргэжлийн холбооны үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн холбооны ашиг сонирхлыг хувийн ашгаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон энэ журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.

б/ Мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал

№	Албан тушаал	Овог, Нэр

Тэмдэглэл: Гүйцэтгэх захирлын мэдээллийг энэ журмын гуравдугаар хавсралтад заасны дагуу бичиж холбогдох баримт бичгийг хавсаргах.

□ Дээрх иргэдийн ёс зүй, бизнесийн нэр хүнд нь мэргэжлийн холбоог удирдахад харшлахгүй, мэргэжлийн холбооны үйл ажиллагааг шударга, үр ашигтайгаар удирдах мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн холбооны ашиг сонирхлыг хувийн ашгаас дээгүүр тавих ёс суртахууны төлөвшилттэй, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах чадвартай, зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа хугацаа хэтэрсэн өргүй, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцоогүй, ял шийтгэлгүй гэдгийг судалж Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон энэ журмын дагуу шаардлага хангасан гэж үзсэн тул эрх бүхий албан тушаалд томилсон болно.

V. Хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн хавсралт		
1	Хүсэлт гаргасан албан бичиг	
2	Бүртгүүлэх хүсэлт /энэ журмын нэгдүгээр хавсралт/	
3	Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар	
4	УБЕГ-т бүртгүүлсэн Мэргэжлийн холбооны дүрмийн эх хувь	
5	Удирдах зөвлөлийн дарга, гишүүн болон гүйцэтгэх захирлын мэдээлэл /энэ журмын гуравдугаар хавсралт/	
6	Удирдах зөвлөлийн дарга, гишүүн болон гүйцэтгэх захирал томилсон шийдвэр, иргэний үнэмлэхийн баталгаажсан хуулбар	
7	Гишүүнээр элсүүлэхэд тавих шаардлага, гишүүнчлэлийн хураамж, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах журам эх хувь	
8	Мэргэжлийн ёс зүйн дүрэм эх хувь	
9	Гомдол, маргааныг шийдвэрлэх журам эх хувь	
10	Гишүүдэд сургалт явуулах, мэргэшлийн үр чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах журам эх хувь	
11	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10.8-д заасан асуудлаар дүгнэлт гаргах журам эх хувь	
<i>Бүгд хуудас</i>		
<p><input type="checkbox"/> Дээрх баримт бичгүүдийг “Виртуал хөрөнгийн үйлчилгээ мэргэжлийн холбоонд тавих шаардлагыг тогтоох журам”-ын дагуу үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа, хуурамч мэдээлэл үгүй болно.</p>		

Үнэн зөв мэдээлсэн:

Удирдах зөвлөлийн дарга

/гарын үсэг/

/огноо/

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын хоёрдугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ХАЯГ БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭЭЛЭХ ХҮСЭЛТ

Хүсэлт гаргасан огноо	Он		Сар	Өдөр		
Хүсэлт гаргагч Мэргэжлийн холбооны нэр						
Регистрийн дугаар						
Мэдээллийн төрлийг сонгох (тохирох нүдэнд “√” тэмдэглэгээ тавих)						
<input type="checkbox"/> Удирдах зөвлөлийн дарга		<input type="checkbox"/> Удирдах зөвлөлийн гишүүн				
<input type="checkbox"/> Хаяг байршил		<input type="checkbox"/> Гүйцэтгэх захирал				
I. Удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын мэдээлэл						
№	Овог, нэр	Томилсон шийдвэрийн огноо, дугаар	Албан тушаал			
Тэмдэглэл: Албан тушаалд өөрчлөлт орсон хүн бүрийг жагсаах ба энэ журмын гуравдугаар хавсралтад заасны дагуу мэдээллийг бичиж холбогдох баримт бичгийг хавсаргах.						
II. Мэргэжлийн холбооны шинэ хаяг байршлын талаарх мэдээлэл						
Мэргэжлийн холбооны дүрэмд хаяг байршлыг тусгах асуудал хэлэлцсэн бүх гишүүдийн хурлын шийдвэрийн дугаар, огноо			/он/	/сар/	/өдөр/	/дугаар/
Хаяг байршил	Аймаг/ хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Утас					
<input type="checkbox"/> Худалдаж авсан <input type="checkbox"/> Түрээссэлсэн <input type="checkbox"/> Бусад		<i>/тохирохыг сонгож “√” тэмдэглэгээ тавих/</i>				
Тэмдэглэл:						
<ul style="list-style-type: none"> - Өөрчлөлт орсон хаяг, байршил/гүйцэтгэх захирлыг бүртгэсэн Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар; - Шинэ хаяг, байршил тусгагдсан Мэргэжлийн холбооны дүрмийн эх хуулбар тус тус хавсаргах. 						

Үнэн зөв мэдээлсэн:

Удирдах зөвлөлийн дарга

/Гарын үсэг/

/огноо/

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын гуравдугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

I. Товч танилцуулга				
Ургийн овог				
Овог				
Нэр				
Төрсөн огноо				
Регистрийн дугаар				
Иргэншил				
Оршин суугаа хаяг				
Цахим шуудангийн хаяг				
Суурин болон гар утасны дугаар				
II. Ажлын танилцуулга				
Одоо ажиллаж байгаа байгууллага				
Албан тушаалын нэр				
Ажлын чиг үүрэг				
Ажлын хаяг, утасны дугаар				
Мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр/ гүйцэтгэх захирлаар томилогдсон шийдвэрийн огноо, дугаар				
Сүүлийн 3 жилийн хугацаанд ажилласан байгууллага	Албан тушаалын нэр	Ажлын чиг үүрэг	Албан тушаалд томилогдсон огноо	Ажлаас гарсан огноо, шалтгаан
III. Боловсролын байдал (Ерөнхий боловсрол болон их дээд сургууль)				
Хаана	Сургуулийн нэр	Он сар өдөр		Зэрэг, цол
		Элссэн	Төгссөн	

IV. Гэр бүлийн байдал (гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагчийн мэдээлэл)			
№	Овог, нэр, регистрийн дугаар	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал, холбоо барих утас
1			
2			
...			

Иргэний үнэмлэх болон Мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн дарга, гишүүнээр томилогдсон шийдвэрийн хуулбарыг тус тус хавсаргав.

Тодорхойлолтыг үнэн зөв гаргасан болно.

(нэр)

(гарын үсэг)

_____ он _____ сар _____ өдөр



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

**“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
үйл ажиллагаанд зайны болон газар дээрх
хяналт шалгалт хийх журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

*Санхүүгийн зохицуулах хорооны 2022
оны 05 дугаар сарын 25-ны өдрийн
305 дугаар тогтоолын хавсралт*

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч /цаашид “ВХҮҮ” гэх/ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, зааврыг биелүүлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Хорооноос баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-аар ВХҮҮ-ийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалттай холбоотой нийтлэг харилцааг зохицуулж, энэ журмаар нарийвчилсан харилцааг зохицуулна.

1.3.ВХҮҮ-ийн хяналт шалгалтын болон эрсдэлийн үнэлгээний хувийн хэргийг Хорооны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий газар, нэгж бүрдүүлж, хөтөлнө.

1.4.Хороо хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ “Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын бодлогын баримт бичиг”-т заасан зарчмыг баримтална.

Хоёр.Хяналт шалгалтын төрөл, хэлбэр

2.1.Хорооноос хийх хяналт шалгалт нь дараах төрөлтэй байна:

2.1.1.зайны хяналт шалгалт;

2.1.2.газар дээрх хяналт шалгалт.

2.2.Хяналт шалгалтыг хянан шалгагч, улсын байцаагч хэрэгжүүлнэ. Газар дээрх хяналт шалгалтыг зөвхөн улсын байцаагчийн эрхтэй хянан шалгагч хэрэгжүүлж, ажлын хэсгийг удирдана. Шаардлагатай гэж үзвэл бусад алба хаагчийг ажлын хэсгийн гишүүнээр ажиллуулж болно.

2.3.Хянан шалгагч, улсын байцаагч нь хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам” болон энэ журмын хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

Гурав.Зайны хяналт шалгалт

3.1.Зайны хяналт шалгалтаар ВХҮҮ нь хууль тогтоомж, холбогдох нөхцөл шаардлага, журмыг биелүүлж байгаа эсэхийг хянах, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах замаар учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой байна.

3.2.Зайны хяналт шалгалтыг дараах үндэслэл, арга хэлбэрээр хэрэгжүүлнэ:

3.2.1.эрсдэлийн үнэлгээ, асуулгаар;

3.2.2.тусгайлсан программ хангамжаар;

3.2.3.ВХҮҮ болон холбогдох бусад этгээдээс ирүүлсэн тайлан, мэдээлэл;

3.2.4.хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад арга, хэлбэр.

3.3.ВХҮҮ зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах мэдээ, тайланг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу Хороонд тогтоосон хугацаанд ирүүлнэ:

3.3.1.ВХҮҮ-ийн арилжааны мэдээг сар бүр энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу цахим хэлбэрээр дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх;

3.3.2.ВХҮҮ-ийн арилжаанд оролцогчдын мэдээг сар бүр энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу цахим хэлбэрээр дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх;

3.3.3.мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг хагас болон жилийн эцсээр Хорооноос баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 4.9-т заасны дагуу цахим хэлбэрээр 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор болон дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх.

3.4.ВХҮҮ-ээс ирүүлэх мэдээ, тайлан дараах шаардлагыг хангасан байна:

3.4.1.тогтоосон хугацаанд үнэн зөв, хавсралтад заасны дагуу ирүүлсэн байх;

3.4.2.тухайн мэдээ, тайланг өмнө нь өгч байсан бол түүнтэй нийцсэн байх, өөрчлөгдсөн тохиолдолд тайлбар, тодруулга үндэслэлтэй байх.

3.5. Хороо шаардлагатай тохиолдолд ВХҮҮ-ээс ирүүлсэн мэдээ, тайланд нэмэлт тодруулга, тайлбарыг холбогдох нотлох баримтын хамт шаардаж болно.

Дөрөв. Газар дээрх хяналт шалгалт

4.1. Хороо газар дээрх хяналт шалгалтыг иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хийнэ.

4.2. Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

4.3. Газар дээрх хяналт шалгалтыг дараах үндэслэлээр хийнэ:

4.3.1. энэ журамд заасан зайны хяналт шалгалтын дүгнэлт;

4.3.2. төрийн эрх бүхий байгууллага, иргэдээс ирүүлсэн зохих нотлох баримттай санал, дүгнэлт, гомдол;

4.3.3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 8.2, 8.3-т заасан үүргийг хэрэгжүүлээгүй;

4.3.4. өмнө хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн хэрэгжилтийг тооцох;

4.3.5. ВХҮҮ-ийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмж;

4.3.6. ВХҮҮ тус журмын 3.3, 3.4, 3.5 дах хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлээгүй.

4.4. Газар дээрх хяналт шалгалт хийхэд ВХҮҮ-ийн эрх бүхий албан тушаалтныг байлцуулах бөгөөд тухайн албан тушаалтан ирээгүй нь уг шалгалтыг хойшлуулах үндэслэл болохгүй.

4.5. Ажлын хэсэг газар дээрх хяналт шалгалтын тайланг ВХҮҮ-ийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулна.

4.6. ВХҮҮ газар дээрх хяналт шалгалтын тайлантай танилцах эрхтэй.

4.7. Газар дээрх хяналт шалгалтын дүнд илэрсэн зөрчил, дутагдалд шалгалтын тайлангаар болон Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг нээх, эсхүл гэмт хэргийн шинжтэй тохиолдолд харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын хоёрдугаар хавсралт

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭ

№	Асуулгын төрөл	Тоо
1	Нийт бүртгэлтэй харилцагч	
	Үүнээс дотоодын хуулийн этгээдийн	
	Үүнээс гадаад хуулийн этгээдийн	
	Дотоодын харьяалалтай хэрэглэгч	
	Гадаад улсын харьяалалтай хэрэглэгч	
2	0-100.00 сая төгрөг, түүнтэй тэнцэх виртуал хөрөнгийн данстай хэрэглэгч	
	100-500.00 сая төгрөг, түүнтэй тэнцэх виртуал хөрөнгийн данстай хэрэглэгч	
	500-1,000.00 сая төгрөг, түүнтэй тэнцэх виртуал хөрөнгийн данстай хэрэглэгч	
	1,000-2,000.00 сая төгрөг, түүнтэй тэнцэх виртуал хөрөнгийн данстай хэрэглэгч	
	2,000.00 сая төгрөг, түүнтэй тэнцэх виртуал хөрөнгөөс их данстай хэрэглэгч	
3	Арилжаанд оролцсон хэрэглэгч	
4	Гадаад улсаас бүртгүүлсэн хэрэглэгч	
5	Дотоод виртуал хөрөнгө эзэмшиж буй харилцагч	
6	Нийт харилцагчийн мөнгөн хөрөнгө	



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 306

Улаанбаатар хот

**“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн
үйл ажиллагааг хязгаарлах, түр зогсоох,
бүртгэлээс хасах журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах журам”-ыг хавсралтаар баталсугай.

Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2022
оны 05 дугаар сарын 25-ны өдрийн
306 дугаар тогтоолын хавсралт

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ, ТҮР ЗОГСООХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-нд бүртгэлтэй Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч /цаашид “ВХҮҮ” гэх/-ийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох, түр зогсоох, бүртгэлээс хасахтай холбогдох харилцааг зохицуулна.

Хоёр. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоох

2.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10.10-т заасан үйл ажиллагаа болон тухайлсан виртуал хөрөнгө, түүнтэй холбоотой бүтээгдэхүүнд Хорооноос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор хязгаарлалт тогтоож болно.

2.2.Хязгаарлалт тогтоох нь ВХҮҮ-ийн зайны болон газар дээрх хяналт шалгалт, бусад эрх бүхий байгууллагын дүгнэлт, зөвлөмж, мэдэгдэл, анхааруулга, тодорхойлолт зэрэгт үндэслэнэ.

2.3.ВХҮҮ нь хязгаарлалтаас чөлөөлүүлэх хүсэлтээ нотлох баримтын хамт Хороонд ирүүлж болох бөгөөд ирүүлсэн хүсэлтийг ажлын 20 өдрийн дотор Хороо хянаж, шийдвэрлэнэ.

2.4.Энэ журмын 2.2-т заасан мэдэгдлийн шалтгаан, нөхцөл байдал арилсан гэж Хороо үзвэл хязгаарлалтаас чөлөөлнө.

2.5.Хороо хязгаарлалт тогтоосон болон хязгаарлалтаас чөлөөлсөн шийдвэрээ олон нийтэд нээлттэй байршуулна.

Гурав. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн Үйл ажиллагааг түр зогсоох

3.1.Хорооноос дараах тохиолдолд ВХҮҮ-ийн үйл ажиллагааг 3 сар хүртэл хугацаагаар түр зогсоож болно:

3.1.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, бусад

холбогдох хууль тогтоомж болон салбарын зохицуулалтын журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах талаар Хорооноос хүргүүлсэн албан шаардлагыг заасан хугацаанд хангаж ажиллаагүй, үүргээ биелүүлээгүй;

3.1.2.Хороо, түүний хянан шалгагчаас ВХҮҮ-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор 2 болон түүнээс дээш удаа мэдэгдэл, анхааруулга хүргүүлсэн;

3.1.3.гэмт хэрэг үйлдэх замаар үйл ажиллагаа эрхэлж байгаа талаар эрх бүхий этгээдээс үндэслэл бүхий хүсэлт гаргасан.

3.2.Түр зогсоосон нөхцөл байдал арилсан бол ВХҮҮ нь үйл ажиллагааг сэргээх хүсэлтээ нотлох баримтын хамт Хороонд ирүүлнэ.

3.3.Энэ журмын 3.2-т заасан хүсэлтийг Хороо ажлын 20 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

3.4.Хороо ВХҮҮ-ийн үйл ажиллагааг түр зогсоосон болон сэргээсэн шийдвэрээ олон нийтэд нээлттэй байршуулна.

3.5.Энэ журмын 3.1-т заасны дагуу түр зогсоосон нь харилцагчийн зөвшөөрлөөр түүний виртуал болон мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх ВХҮҮ-ийн эрхийг хязгаарлахгүй.

Дөрөв. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэлээс хасах

4.1.Хорооноос дараах тохиолдолд ВХҮҮ-ийг бүртгэлээс хасна:

4.1.1.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон салбарын зохицуулалтын журамд заасан нөхцөл, шаардлагыг цаашид хангаж ажиллах боломжгүй болсон нь тогтоогдсон;

4.1.2.бүртгүүлснээс хойш 3 сарын дотор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1-т заасан үйл ажиллагааг эрхэлж эхлээгүй;

4.1.3.бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг Хороонд ирүүлсэн, эсхүл татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэр гарсан;

4.1.4.баримт бичгийг хуурамчаар үйлдэн Хороонд бүртгүүлсэн нь тогтоогдсон;

4.1.5.түр зогсоосон хугацаанд үндэслэл болсон нөхцөл байдал, зөрчлийг арилгаагүй;

4.1.6.гэмт хэрэг үйлдэж харилцагчид их хэмжээний хохирол учруулсан нь тогтоогдсон.

4.2.ВХҮҮ-ийг бүртгэлээс хассан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор тухайн компанийг дахин бүртгүүлэхтэй холбоотой хүсэлтийг хүлээн авахгүй.

4.3.ВХҮҮ-ийн бүртгэлээс хасагдсан компани нь төлөвлөгөө, харилцагчтай байгуулсан гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч, тайланг Хороонд ажлын 20 өдрийн дотор ирүүлнэ.

4.4.Хороо бүртгэлээс хассан шийдвэрээ олон нийтэд нээлттэй байршуулна.

4.5.Энэ журмын 4.1-т заасны дагуу бүртгэлээс хассан нь харилцагчийн зөвшөөрлөөр түүний виртуал болон мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийх ВХҮҮ-ийн эрхийг хязгаарлахгүй.

---oO---



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

“Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.11, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс дараах заавар, журмын холбогдох бүлгийг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.
 - 1/ Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 208 дугаар тогтоолоор баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”;
 - 2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 10 дугаар бүлэг;
 - 3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 5 дугаар бүлэг.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

/Энэ тогтоолд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор хассан/

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
179 дүгээр тогтоолын хавсралт

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл, бүртгэлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, гэмт хэрэгтэн, гэмт хэргийн холбогдогч, гэмт бүлэглэлийн гишүүн, тэдгээрийн төлөөлөл санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, аливаа шийдвэр гаргахад нөлөөлөх замаар хууль бус хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах, мөнгө угаах, гэмт хэргийн зорилгоор хөрөнгө хуримтлуулах, гэмт хэргийг санхүүжүүлэх зэрэг хууль бус үйлдэлд ашиглахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

1.2. Хороо дор дурдсан хувь хүн, хуулийн этгээдэд энэхүү журмын дагуу тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина. Үүнд:

1.2.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч, бүртгүүлэхээр хүсэлт гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтан;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан. /

1.2.2. хуулийн этгээдийн хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг эсхүл, эзэмших хүсэлт гаргасан этгээд, хувьцааны дийлэнх хэсгийг, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдүүд хамтран өмчилж байгаа этгээд /цаашид “хувьцаа эзэмшигч” гэх/;

1.2.3. хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, Хорооноос шаардлагатай гэж үзсэн эрх бүхий албан тушаалтан.

1.2.4. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 4.1.4, 7.2-т тус тус заасан холбогдох этгээд, эрх бүхий албан тушаалтан, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмсэн/

1.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгчийн хувьд энэ журмаар заасан асуулгын хүрээнд хяналт тавина.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

1.4. Хороо шаардлагатай тохиолдолд шаталсан байдлаар компанийн нэгдлийн толгой болон охин, хараат компани эсхүл зэргэлдээ компани хүртэл энэхүү журмын шалгуурыг тавина.

Хоёр. Тохиромжтой этгээдийн шалгуур

2.1. Хороо дараах шалгууруудыг хангасан этгээдийг тохиромжтой этгээд гэж үзнэ. Үүнд:

2.1.1 Хуулийн этгээдэд дараах шалгуур тавигдана. Үүнд:

2.1.1.1. санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадвартай байх;

2.1.1.2. бодлого зохицуулалт, баталгаатай байх;

2.1.1.3. төрийн эрх бүхий байгууллагаас албадлагын эсхүл захиргааны шийтгэлгүй байх;

2.1.1.4. бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх;

2.1.1.5. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.1.1.6. хуульд заасан бусад.

2.1.2 Хувь хүнд дараах шалгуур тавигдана. Үүнд:

2.1.2.1. мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх;

2.1.2.2. гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;

2.1.2.3. ёс зүйн нэр хүндтэй байх;

2.1.2.4. ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх;

2.1.2.5. хуульд заасан бусад.

2.2. Хуулийн этгээд нь оффшор гэж нэрлэгдэх татвараас чөлөөлөгдөх бүсэд харьяалалтай байвал Хороо тухайн этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, гүйцэтгэх удирдлага, ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлох нэмэлт баримт бичгийг шаардаж болно.

2.3. Эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд түр орон гүйцэтгэхээр томилогдсон тухайн этгээд мөн тохиромжтой этгээдийн шалгуур хангасан байна.

2.4. Салбар, төлөөлөгчийн газар эсхүл охин, хараат компаниараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулах гадаад улсын харьяалалтай хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд энэхүү журмын 3.1-д заасан шалгуур хамаарч болно.

2.5. Энэ журмын 1.2, 1.3 дахь хэсгийг хангасан тохиромжтой этгээд гэдгийг тодорхойлох асуулгыг Хорооны даргын тушаалаар батална.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмсэн/

Гурав. Тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлох

3.1. Энэхүү журмын 2.1.1-д заасан хуулийн этгээдэд тавигдах шалгуурууд нь дараах байдалтай байна.

3.1.1. энэхүү журмын 2.1.1.1-д заасан “Санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадвартай байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.1.1.1. хэвийнээс бусад зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

3.1.1.2. энэхүү журмын 1.2-т заасан хуулийн этгээдийн хувьд санхүүгийн хүндрэлд орж төлбөрийн чадваргүй болсон эсэх.

3.1.2. энэхүү журмын 2.1.1.2-т заасан “Бодлого зохицуулалт, баталгаатай байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.1.2.1. төлөөлөн удирдах зөвлөл, түүнтэй адилтгах удирдлагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх, терроризмтой тэмцэх чиглэлээр тавигдах шаардлага, ёс зүйн шалгуур зэргийг тусгасан бодлого, журам, хөтөлбөртэй байх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.1.2.2. хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, холбогдох хууль

тогтоомжийн дагуу зохицуулагдах үйл ажиллагааг шударга, өөрийн болон бусад оролцогч талууд, үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлэн гүйцэтгэхийг илэрхийлсэн баталгаа гаргах.

3.1.3. энэхүү журмын 2.1.1.3-т заасан “төрийн эрх бүхий байгууллагаас албадлагын эсхүл захиргааны шийтгэлгүй байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.1.3.1. Хорооны зохицуулалттай хуулийн этгээдийн хувьд өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хязгаарлах, түр зогсоох, бүртгэлээс хасах арга хэмжээ авхуулсан эсэх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

3.1.3.2. Хорооны зохицуулалттай болон бусад хуулийн этгээдийн хувьд өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх;

3.1.4. энэхүү журмын 2.1.1.4-т заасан “бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.1.4.1. санхүүгийн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол буруутан байсан эсэх;

3.1.4.2. сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;

3.1.4.3. Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрчсөн, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;

3.1.4.4. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.

3.1.5. энэхүү журмын 2.1.1.5-т заасан “ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.1.5.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд харшлаагүй байх;

3.1.5.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль, журамд харшлаагүй байх.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.2. Энэхүү журмын 2.1.2-т заасан хувь хүнд тавигдах тавигдах шалгуурууд нь дараах байдалтай байна.

3.2.1. энэхүү журмын 2.1.2.1-д заасан “Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд:

3.2.1.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага, эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтан зэрэг эрх бүхий албан тушаалд томилогдох этгээдүүд нь:

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/

а) Банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн болон Хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн бусад мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;

б) Тухайн албан тушаалд дүйцэхүйц албан тушаалд 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай байх;

в) Санхүүгийн салбарт 2-аас доошгүй жил ажилласан байх.

3.2.1.2. хоршооны тэргүүлэгчдийн зөвлөл болон хяналтын зөвлөл, зээлийн хороонд томилогдох этгээдүүдийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34.3, 34.4, 34.11-т заасан шаардлага, гүйцэтгэх захиралд мөн хуулийн 39.6-д заасан шаардлагын дагуу тавина;

3.2.1.3. Банкнаас бусад санхүүгийн салбарын агент нь:

а) Банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн болон Хорооноос бусад хүлээн зөвшөөрөгдсөн бусад мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;

б) Санхүүгийн салбарт 1-аас доошгүй жил ажилласан байх.

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд:

3.2.1.4. төлөөлөн удирдах зөвлөл, салбарын удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалд томилогдох этгээдүүд нь:

- а) Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой байх;
- б) Хорооноос хүлээн зөвшөөрсөн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх.

3.2.1.5. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэх удирдлага болон Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан нь санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын нэг, эсхүл хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн байх.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмсэн/

3.2.2. энэхүү журмын 2.1.2.2-т заасан “гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.2.2.1. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх;

3.2.2.2. Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбогдон шалгагдах болон шүүх хуралд шүүгдэгчээр, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжиглэгдэж байгаа эсэх.

3.2.3. энэхүү журмын 2.1.2.3-т заасан “ёс зүйн нэр хүндтэй байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.2.3.1 сүүлийн 1 жилийн хугацаанд өөрийн буруутай үйлдлээс, салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн ажлаас халагдах арга хэмжээ авхуулаагүй байх;

3.2.3.2 санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол буруутан байсан эсэх;

3.2.3.3. сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;

3.2.3.4. Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрчсөн эсэх, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;

3.2.3.5. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.

3.2.4 энэхүү журмын 2.1.2.4-д заасан “Ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

3.2.4.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд харшлаагүй байх;

3.2.4.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль, журамд харшлаагүй байх.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Дөрөв. Тохиромжтой этгээдийн шалгуур хангасан эсэхийг тодорхойлох баримт бичгийг бүрдүүлэх

4.1. Энэхүү журмын 1.2-т заасан этгээд өөрийн тохиромжтой этгээд болохоо нотлох баримтыг бүрдүүлж, Хороонд ирүүлэх үүрэгтэй.

4.2. Энэхүү журмын 1.2-т этгээд нь журмын 3 дугаар бүлэг дэх тохиромжтой этгээдийн шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд тохиромжтой этгээд гэж үзнэ.

4.3. Энэхүү журмын 3 дугаар хавсралт болон журмын 3 дугаар бүлэг дэх тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан болохыг нотлох баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн тухайн салбарын тусгайлсан журамд заагдсан хугацаанд Хороонд ирүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.4. Хороо тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохдоо шаардлагатай дараах нотлох баримтыг цуглуулж болно. Үүнд:

4.4.1. Монгол Улсын төрийн болон хууль хяналтын байгууллага, мэргэжлийн холбоо, зохицуулалтын бусад холбогдох байгууллагуудаас мэдээлэл, лавлагаа;

4.4.2. гадаад улсын төрийн болон хууль хяналтын байгууллага, мэргэжлийн холбоо, зохицуулалтын бусад холбогдох байгууллагуудаас мэдээлэл, лавлагаа.

4.5. Гадаад улсын харьяалалтай хуулийн этгээд, иргэн бол хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч этгээд, иргэнтэй

холбоотой дараах баримт бичгийг нэмж ирүүлэхийг шаардаж болно. Үүнд:

4.5.1.Харьяалах улсад зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;

4.5.2.Харьяалах улсад гааль, татварын өр, төлбөргүй болохыг нотлох баримт бичиг;

4.5.3.Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг.

4.6. Хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 1.2-т заасан этгээдээс ярилцлага авч, нэмэлт мэдээлэл шаардаж болно.

4.7. Хороо тохиромжтой этгээд мөн эсэхийг энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасан тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлно.

4.8. Хороо дараах тохиолдолд тохиромжтой этгээдийн шалгуурыг заавал тодорхойлно. Үүнд:

4.8.1. Хорооны зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй, эсхүл тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах, бүртгүүлэхээр Хороонд хандсан;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.8.2. энэхүү журмын 1.2-т заасан хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хадгаламж, зээлийн хоршооны сонгуульд гишүүдэд өөрчлөлт оруулах;

4.8.3. эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.8.4. бусад тохиолдолд.

4.9. Хороо нь ирүүлсэн хүсэлтийг тухайн салбарын тусгайлсан журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.10. Эцсийн өмчлөгчид орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдэгдэнэ.

Тав. Тохиромжтой этгээдийн хяналт

5.1. Тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд Хороо зайны болон газар дээрх хяналт шалгалтаар байнгын хяналт тавина.

5.2. Энэхүү журмын 1.2-т заасан этгээд 3 дугаар бүлэгт заасан шалгуурыг хангаагүй, эсхүл дараах үйлдэл гаргасан нь хяналт шалгалтаар илэрсэн

тохиолдолд Хороо тохиромжтой бус этгээд гэж үзэх үндэслэл болно. Үүнд:

5.2.1. эцсийн өмчлөгчийг болон холбогдох бусад мэдээллийг нуун дарагдуулсан;

5.2.2. хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүслийг худал мэдээлсэн;

5.2.3. хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, худал ташаа мэдээлэл өгсөн.

5.3. Хороо тохиромжтой бус этгээд гэж үзсэн тохиолдолд холбогдох мэдэгдлийг тухайн этгээдэд хүргүүлнэ.

5.4. Энэхүү журмын 1.2-т этгээд нь тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаагүй, хангахгүй болсон тохиолдолд Хороо холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авна.

5.5. Хороо тохиромжтой этгээдийн шалгуур хангахгүй болсон этгээдийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

*Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны дүгээр тогтоолоор баталсан
“Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес,
мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх
тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 3 дугаар хавсралт*

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1.	Энэ журмын 2.3-д заасан асуулга / Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан. /	
2.	Эрх бүхий этгээдээс ирүүлсэн өргөдөл, шийдвэр, холбогдох баримт бичиг	
3.	Тохиромжтой этгээд нь хуулийн этгээд бол энэхүү журмын 3.1.2.1-д заасныг хангах бодлого, журам	
4.	Тохиромжтой этгээд нь хуулийн этгээд бол энэхүү журмын 3.1.2.2-д заасныг хангах баталгаа /албан бичиг, хавсралт/	
5.	Тохиромжтой этгээд нь хуулийн этгээд бол санхүүгийн тайлан, төлбөрийн чадварын үзүүлэлт	
6.	Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл,	
7.	Тохиромжтой этгээдийн боловсролын зэргийг нотлох баримт бичиг	
8.	Тохиромжтой этгээдийн салбартаа болон тухай албан тушаалд дүйцэхүйц ажлын туршлагатай болохыг нотлох баримт бичиг	
9.	Тохиромжтой этгээдийн Хорооноос зөвшөөрөгдсөн сургалтад суусан болохыг нотлох гэрчилгээ	
10.	Тохиромжтой этгээдийн гэмт хэрэгт холбогдож байгаагүйг батлах эрх бүхий байгууллагын лавлагаа, холбогдох баримт бичиг	
11.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт болон холбоотой шүүхийн зарлан түүнтэй адилтгах мэдэгдэл байгаа эсэх	
12.	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг	



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛГА БАТЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 1.2-т заасан тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг нэгдүгээр хавсралтаар, мөн журмын 1.3-т заасан эцсийн өмчлөгч хувь хүний асуулгыг хоёрдугаар хавсралтаар, хуулийн этгээдийн асуулгыг гуравдугаар хавсралтаар, хянагчийг тодорхойлох асуулгыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-д даалгасугай

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 344 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ АСУУЛГА

/Журмын 1.2-т заасан этгээдийн хувийн мэдээллийн асуулга/

№	Асуулт	Хариулт
1.	Таны ажиллаж буй байгууллагын нэр	
2.	Овог Нэр Өөр нэртэй байсан эсэх Хүйс (Эрэгтэй/Эмэгтэй)	
3.	“Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 1.2-т заасан этгээдийн аль нь болох, албан тушаал? Хуулийн этгээд, Зөвлөлийн гишүүн, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага, ажилтан, агент гэх мэт?	
4.	Оршин суугаа хаяг	
5.	Өнгөрсөн 10 жилийн хугацаанд оршин сууж байсан хаяг (хамаарах огноог тавих)	
6.	Төрсөн огноо Төрсөн газар (улс, аймаг, хот)	
7.	Иргэншил, Хэрэв гадаад улсын иргэн байсан бол иргэншил авсан төрлийг бичнэ үү. (жишээ нь, төрөлт, иргэний харьяаллаа өөрчлөх, гэрлэлт)	
8.	Регистрийн дугаар	
9.	Одоогийн хашиж буй албан тушаал эсвэл хийж буй ажил болон мэргэжил, сүүлийн 10 жилийн хугацаанд ажиллаж байсан байгууллага, ажил олгогчийн нэр, эрхэлдэг бизнес, хашиж байсан албан тушаал, холбогдох огноо, ажлаас гарсан огноо болон хийж байсан ажил бүрийн хувьд: i. эрхэлж байсан албан тушаалын нэр; ii. ажилд орсон огноо; iii. ажил олгогчийн нэр, хаяг; iv. тодорхойлолт гаргагчийн нэр, албан тушаал, утасны дугаар	
10.	Та одоо бүртгэгдсэн байгууллагын– (a)захирал эсвэл хянагч үү? (b)сүүлийн 10 жилийн хугацаанд захирал эсвэл хянагчаар ажиллаж байсан үү? (тохиолдол бүр болон бизнесийн төрлийн хувьд үүсгэн байгуулагдсан улсын нэрийг бичих)	

11.	Санхүүгийн байгууллагад эзэмшдэг хувь эзэмшлийн мэдээлэл (одоогийн болон сүүлийн 10 жилийн хугацаанд) (a)компанийн нэр (b)үүсгэн байгуулагдсан улс (c)эзэмшлийн хувь (d)бизнесийн төрөл	
12.	(a)эзэмшсэн боловсрол, төгссөн жил (b)боловсролын зэрэг	
13.	Төрийн байгууллагын аливаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүссэн өргөдөлд татгалзсан хариу авч байсан эсэх?	
14.	Иргэний эсвэл цэргийн эрх бүхий шүүхээс таныг хэрэгт буруутгаж байсан эсэх (a)түхайн хэргийг сүүлийн 10 жилийн дотор давтан үйлдсэн байхаас бусдаар бол насанд хүрээгүй буюу 18 нас хүрээгүй байхдаа үйлдсэн хэрэг эсвэл (b)тээврийн хэрэгслийн ашиглалт, өмчлөлтэй холбоотой хялбаршуулсан байдлаар шийдсэн хэргээс бусад)? Тийм бол хүлээлгэсэн хариуцлага, шийтгүүлсэн бол шийтгэл хүлээлгэсэн огноо, ногдуулсан хэрэг, торгуулийн талаар дэлгэрэнгүй бичих	
15.	Таныг санхүүгийн болон санхүүгийн бус байгууллага, виртуал хөрөнгө гаргагч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан мөрдөн шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
16.	Та хамаарагддаг, хамаарагдаж байсан мэргэжлийн байгууллагаас танд шийтгэл, сахилгын шийтгэл ногдуулах эсвэл мүү үнэлгээ өгөх эсвэл та нөхцөл тавьсан мэргэжлийн үнэмлэхтэй байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
17.	Танаас залилан, луйвар эсвэл ижил төстэй хэргийн шүүх хурал, хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд шинжээч, гэрчийн хувиар бус өөр этгээдийн хувиар нотлох баримт гаргаж өгөхийг шаардаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
18.	Таныг эсвэл таны ажиллаж байгаа эсвэл захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг төрийн, мэргэжлийн эсвэл бусад зохицуулагч байгууллага шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
19.	Та албан тушаалаасаа чөлөөлөгдөх, ажлаасаа халагдах эсвэл таныг мэргэжлээрээ ажиллахыг хориглож байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
20.	Эрх бүхий этгээд эсхүл шүүхээс таныг дампуурсан гэж үзэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
21.	Эрх бүхий шүүхийн шийдвэрийн дагуу та төлбөл зохих, төлөх ёстой өрөө төлөхгүй байсан удаа байгаа юу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
22.	Бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг байгуулах, хянах, удирдахтай холбоотойгоор эрх бүхий шүүхээс танд тэрхүү байгууллага, компани, гишүүний өмнөөс залилан, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэрэг, бусад албан тушаалын гэмт хэрэгт иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	

23.	Таныг ажиллаж байх хугацаанд эсвэл ажиллахаа больсноос хойш нэг жилийн дотор таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийг хүчээр татан буулгах эсвэл зээлдүүлэгчидтэйгээ тохиролцох, зөвшилцөх эсвэл зээлдүүлэгчид нь төлбөрөө буцаан аваагүй эсвэл бүгдийг нь хараахан буцаан аваагүй байхад худалдааг зогсоож байсан тохиолдол гарч байсан уу?Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
24.	Таны захирал, хувьцаа эзэмшигч, менежер, ажилтан, хянагчаар ажиллаж байсан бүртгэгдсэн, бүртгэгдээгүй байгууллага, түншлэлийн эрхийг цуцлах, хүчингүй болгож байсан уу?	
25.	Ажил үүргээ гүйцэтгэхдээ та бусад этгээдэд журам, чиглэл өгөх үүрэгтэйгээр ажиллах уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	

а) Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна. Түүнчлэн, миний бие дээр заасан асуултын хариултын бүрэн дүүрэн байдалд нөлөөлөх аливаа материаллаг өөрчлөлтийг 21 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх үүрэг хүлээж байна.

Огноо:

Гарын үсэг:

*Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 344 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт*

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН АСУУЛГА /ХУУЛИЙН ЭТГЭЭД/

Асуулгыг хүсэлт гаргагчийн эцсийн өмчлөгч бүр бие даан, хүсэлт гаргагчийн туслалцаагүйгээр бөглөнө. Үлдээсэн зай хангалтгүй бол нэмэлт хуудсан дээр бичин хавсаргана.

№	Асуулт	Хариулт
1.	Энэхүү асуулга хамаарах байгууллага ("байгууллага")-ын нэр	
2.	Эцсийн өмчлөгчийн нэрийг бичнэ үү. Үүнд байгууллагын нэр, эрхэлдэг бизнесийн зорилгоор эсвэл холбоотой ашигладаг аливаа хуулийн этгээдийн нэрийг бичих	
3.	Бизнесийн мэдээлэл	
4.	Өмнө нь бүртгүүлсэн эсвэл сольсон нэр Хуулийн этгээдийн албан ёсны нэр болон регистрийн дугаар	
5.	Үүсгэн байгуулагдсан улс, огноо	
6.	(a) Төв оффисын бүртгэлтэй хаяг (b) Оршин байгаа газар, хаяг	
7.	Эцсийн өмчлөгчөөр бүртгэгдэж байсан эсвэл бүртгэлтэй эсэх	
8.	7-р асуултад тийм гэж хариулсан бол үүнээс Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай салбарын оролцогч мөн эсэх. Тийм бол эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн эсвэл бүртгэлтэй байгаа хуулийн этгээдийн нэрийг бичнэ үү.	
9.	Эцсийн өмчлөгч нь Монгол Улс эсхүл бусад улс оронд санхүүгийн болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч, виртуал хөрөнгө гаргагч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр зөвшөөрөл авах, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан, гаргаж байгаа эсэх?	
10.	Монгол улс эсвэл бусад улс оронд захиргааны шийдвэр гаргуулж байсан эсэх? Тийм бол дэлгэрэнгүйг бичих	
11.	Тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь өөр байгууллагын хувьцааг эзэмшдэг эсэх. Тийм бол хувьцаа эзэмшлийн хэмжээ болон саналын эрхийг дэлгэрэнгүй бичих	
12.	Эцсийн өмчлөгчийн санхүүгийн сүүлийн 3 жилийн аудитын тайланг ирүүлнэ үү (групийн аудитын тайланг мөн ирүүлэх). Хамгийн сүүлийн үеийн байдлаар тайланд 6 сарын өмнө аудит хийсэн бол тэрхүү аудитын тайланд удирдлагын тайланг хавсарган илгээнэ (удирдлагын тайланд аудит хийсэн байх шаардлагагүй). Удирдлагын тайланд одоогийн санхүүгийн байр суурь, үр дүнг харуулсан байх. Мөн дүрэм, гэрчилгээ гэх мэт баримт бичгийн хуулбарыг ирүүлнэ үү.	

13.	Энэхүү асуулгыг зөвшөөрөл авах хүсэлтэй холбоотой ирүүлсэн бол хүсэлтийг шийдэхэд эцсийн өмчлөгчид туслалцаа болох бусад мэдээллийг ирүүлнэ үү.	
14.	Эцсийн өмчлөгч нь сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол улс эсвэл бусад улс оронд шүүхийн шийдвэрийн дагуу төлбөл зохих өр төлбөрөө төлөөгүй тохиолдол гарч байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
15.	Эцсийн өмчлөгч нь сүүлийн 10 жилийн хугацаанд төлж дуусаагүй өр зээлтэй эсэх, зээлдүүлэгч талтай тохиролцоо, хэлцэл хийн төлөх хугацааг хойшлуулж байсан эсэх талаар дэлгэрэнгүй бичих	
16.	Монгол Улсад эцсийн өмчлөгч хөрөнгийн итгэмжлэгч, хүлээн авагчаар томилогдсон/ томилогдож байсан эсэх, эсхүл сүүлийн 10 жилийн хугацаанд бусад улс оронд ижил төстэй үйлдэл, үйл ажиллагаа эрхэлсэн эсэх? Хэрэв тийм бол тухайн итгэмжлэгч, үүрэг хүлээгч үүргээ хэрэгжүүлж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй бичих	
17.	Монгол Улсад эцсийн өмчлөгчийн өмч, хөрөнгийг татан буулгах тухай мэдэгдэл өгч байсан эсэх, эсхүл сайн дурын үндсэн дээр татан буугдсан эсэх, сүүлийн 10 жилийн хугацаанд үүнтэй ижил төстэй тохиолдол гарсан эсэх талаар дэлгэрэнгүй бичих	
18.	Монгол Улс эсхүл олон улсад сүүлийн 10 жилд эцсийн өмчлөгчийг албадан татан буулгах тохиолдол гарсан эсэх талаар дэлгэрэнгүй бичнэ үү.	
19.	Хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагаас эцсийн өмчлөгчийн бизнесийн үйл ажиллагаанд шалгалт хийж байгаа юу эсвэл өмнө нь тийнхүү шалгаж байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
20.	Монгол Улс эсвэл бусад улс оронд зохицуулагч байгууллага ирээдүйд байгуулах гэрээтэй холбогдуулан эцсийн өмчлөгчийг буруушаах, хэрэгт татах, сануулах, сахилгын шийтгэл ногдуулах, нийтэд нээлттэй шүүмжилж байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
21.	Эцсийн өмчлөгчийг Монгол Улс эсвэл бусад улс оронд зохицуулалттай салбарын нийгэмлэгт элсүүлэхээс татгалзаж байсан үү эсвэл эцсийн өмчлөгч хандсаныхаа дараа элсэх хүсэлтээ цуцалж байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
22.	Эцсийн өмчлөгч нь Монгол Улс эсвэл бусад улс оронд байгууллагын санхүүгийн чадавх, материаллаг баазад нөлөө үзүүлэхүйц шүүх ажиллагаанд оролцсон/оролцож байгаа эсэх? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй бичих	
23.	Эцсийн өмчлөгч томоохонд тооцогдох хэлцэл, гүйлгээ хийсэн/ хийхээр төлөвлөж байгаа эсэх (ногдол ашиг авах тооцогдохгүй)	
24.	Эцсийн өмчлөгчийн бизнесийн үйл ажиллагаанд хувь хүн/хуулийн этгээд баталгаа гаргах эсвэл хамтран оролцсон эсэх? Эсвэл цаашид хамтрахаар төлөвлөж буй бол дэлгэрэнгүй бичих	
25.	Байгууллагын хэдэн ширхэг хувьцаа эцсийн өмчлөгч эсвэл салбар компанийн нэр дээр бүртгэлтэй байдаг вэ? Бүртгэлтэй нэр, хувьцааны ангиллыг бичих	
26.	Эцсийн өмчлөгч эсвэл ижил группд байдаг компани эсвэл хамааралтай этгээд тухайн байгууллага (эцсийн өмчлөгч эсвэл салбар компанийн нэр дээр бүртгэгдээгүй)-ын хэдэн хувьцааг сонирхож байна вэ? (үр шим хүртэх зорилгоор)	

27.	Эцсийн өмчлөгч эсвэл салбар компаниуд итгэл хүлээгч эсвэл нэрлэсэн хувьцаа эзэмшигчийн хувиар байгууллагад хувьцаа эзэмшдэг үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
28.	25, 26, 27-р асуултуудад өгсөн хариултуудад дурдсан байгууллагын хувьцааг ямар нэгэн этгээдэд шударгаар эсвэл хууль ёсоор санал болгох эсвэл барьцаалсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
29.	Тухайн байгууллага (эсвэл охин компани нь болох өөр байгууллага)-ын хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хэрэгжүүлэх саналын эрхийн хэдэн хувийг эцсийн өмчлөгч болон салбар компани хэрэгжүүлэх эсвэл хэрэгжилтийг нь хянах эрхтэй вэ?	
30.	Энэхүү асуулгыг зөвшөөрөл авах хүсэлттэй холбоотой ирүүлсэн бол хүсэлтийг шийдэхэд эцсийн өмчлөгчид туслалцаа болох бусад мэдээллийг ирүүлнэ үү.	
31	<p>Тухайн байгууллага нь хянагчтай эсэх. /Хянагчийг дор дурдсан үйл ажиллагааг эрхэлдэг этгээдийг хамааруулан ойлгоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-т заасан эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтныг томилох, огцруулах эрхтэй; • Тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд саналын эрхтэй; • Тухайн хуулийн этгээдийн өмч, хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй; • Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-т заасан эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтны үйл ажиллагааг удирдан чиглүүлж байгаа; • Тухайн хувь хүн эсхүл хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөө үзүүлэх эрхтэй; • Тухайн хуулийн этгээдийн дүрэм журам, баримт бичигт өөрчлөлт оруулах эрхтэй; • Тухайн хувь хүн эсхүл хуулийн этгээдийн үйл ажиллагаанд санал өгөх эрхтэй; • Бусад./ <p>Хэрэв тийм бол хянагчид зориулсан асуулгын хуудсыг хянагч тус бүрээр бөглөнө.</p>	

БАТАЛГАА

Миний бие/Бид дээр мэдүүлсэн мэдээллийг үнэн, зөв болохыг баталж байна.

Миний бие/Бид энэхүү баталгаанд чухал аливаа өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлнэ.

20___ оны ___ сарын ___ өдөр

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ: _____

БАЙГУУЛЛАГЫН НЭР: _____

*Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 344 дүгээр
тушаалын гуравдугаар хавсралт*

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН АСУУЛГА /ХУВЬ ХҮН/

Асуулгыг хүсэлт гаргагчийн эцсийн өмчлөгч бүр бие даан, хүсэлт гаргагчийн туслалцаагүйгээр бөглөнө. Үлдээсэн зай хангалтгүй бол нэмэлт хуудсан дээр бичин хавсаргана.

№	Асуулт	Хариулт
1.	Эцсийн өмчлөгчийн нэр, регистрийн дугаар	
2.	Оршин байгаа газар, хаяг	
3.	Эцсийн өмчлөгчийн иргэншил	
4.	Эцсийн өмчлөгчөөр бүртгэгдэж байсан эсвэл бүртгэлтэй эсэх	
5.	4-р асуултад тийм гэж хариулсан бол үүнээс Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай салбарын оролцогч мөн эсэх. Тийм бол эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн эсвэл бүртгэлтэй байгаа хуулийн этгээдийн нэрийг бичнэ үү.	
6.	Эцсийн өмчлөгч нь ямар нэгэн хуулийн этгээдийн гишүүнчлэлтэй эсэх? Тийм бол тухайн хуулийн этгээдийн нэрийг бичнэ үү.	
7.	Эцсийн өмчлөгч нь Монгол улс эсхүл өөр улс оронд санхүүгийн болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч, виртуал хөрөнгө гаргагч, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр зөвшөөрөл авах, бүртгүүлэхээр хүсэлт гаргасан, гаргаж байгаа эсэх?	
8.	Эцсийн өмчлөгч нь сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол улс эсвэл бусад улс оронд шүүхийн шийдвэрийн дагуу төлбөл зохих өрөө төлөөгүй тохиолдол гарч байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
9.	Эцсийн өмчлөгч нь сүүлийн 10 жилийн хугацаанд төлж дуусаагүй өр зээлтэй эсэх, зээлдүүлэгч талтай тохиролцоо, хэлцэл хийн төлөх хугацааг хойшлуулж байсан эсэх талаар дэлгэрэнгүй бичих	
10.	Монгол Улсад эцсийн өмчлөгч хөрөнгийн итгэмжлэгч, хүлээн авагчаар томилогдсон/ томилогдож байсан эсэх, эсхүл сүүлийн 10 жилийн хугацаанд бусад улс оронд ижил төстэй үйлдэл, үйл ажиллагаа гаргасан эсэх? Хэрэв тийм бол тухайн итгэмжлэгч, үүрэг хүлээгч үүргээ хэрэгжүүлж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй бичих	
11.	Монгол Улсад эцсийн өмчлөгчийн өмч, хөрөнгийг татан бүүлгах тухай мэдэгдэл өгч байсан эсэх, эсхүл сайн дурын үндсэн дээр татан бүүгдсан эсэх, сүүлийн 10 жилийн хугацаанд үүнтэй ижил төстэй тохиолдол гарсан эсэх талаар дэлгэрэнгүй бичих	
12.	Монгол Улсад эсвэл хаа нэгтээ зохицуулагч байгууллага ирээдүйд байгуулах гэрээтэй холбогдуулан эцсийн өмчлөгчийг буруушаах, хэрэгт татах, сануулах, сахилгын шийтгэл ногдуулах, нийтэд нээлттэй шүүмжилж байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
13.	Эцсийн өмчлөгч нь Монгол Улс, бусад улс оронд байгууллагын санхүүгийн чадавх, материаллаг баазад нөлөө үзүүлэхүйц шүүх ажиллагаанд оролцсон/ оролцож байгаа эсэх? Хэрэв тийм бол дэлгэрэнгүй бичих	
14.	Эцсийн өмчлөгч томоохонд тооцогдох хэлцэл, гүйлгээ хийсэн/ хийхээр төлөвлөж байгаа эсэх (ногдол ашиг авах тооцогдохгүй)	

15.	Байгууллагын хэдэн ширхэг хувьцаа эцсийн өмчлөгч эсвэл салбар компанийн нэр дээр бүртгэлтэй байдаг? Бүртгэлтэй нэр, хувьцааны ангиллыг бичих	
16.	Эцсийн өмчлөгч эсвэл ижил группт байдаг компани эсвэл хамааралтай этгээд тухайн байгууллага (эцсийн өмчлөгч эсвэл салбар компанийн нэр дээр бүртгэгдээгүй)-ын хэдэн хувьцааг сонирхож байна вэ? (үр шим хүртэх зорилгоор)	
17.	Эцсийн өмчлөгч эсвэл салбар компаниуд итгэл хүлээгч эсвэл нэрлэсэн хувьцаа эзэмшигчийн хувиар байгууллагад хувьцаа эзэмшдэг үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
18.	Хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагаас эцсийн өмчлөгчийн бизнесийн үйл ажиллагаанд шалгалт хийж байгаа юу эсвэл өмнө нь тийнхүү шалгаж байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
19.	Эцсийн өмчлөгчийг Монгол Улсад эсвэл гадаад оронд зохицуулалттай салбарын нийгэмлэгт элсүүлэхээс татгалзаж байсан үү эсвэл эцсийн өмчлөгч хандсаныхаа дараа элсэх хүсэлтээ цуцалж байсан үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
20.	Эцсийн өмчлөгчийн бизнесийг үйл ажиллагаанд тухайн байгууллага баталгаа өгөх, баталгаа гаргах, баталгаажуулах эсвэл баталгаа өгөх, гаргах, баталгаажуулах гэж байгаа юу? Жишээ нь хянагч/групп компанийн зээлтэй холбогдуулан банк, санхүүгийн байгууллагад барьцаа өгөх гэх мэт. Тийм бол дэлгэрэнгүй бичих	
21.	<p>Тухайн байгууллага нь хянагчтай эсэх. /Хянагчийг дор дурдсан үйл ажиллагааг эрхэлдэг этгээдийг хамааруулан ойлгоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-т заасан эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтныг томилох, огцруулах эрхтэй; • Тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд саналын эрхтэй; • Тухайн хуулийн этгээдийн өмч, хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй; • Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-т заасан эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтны үйл ажиллагааг удирдан чиглүүлж байгаа; • Тухайн хувь хүн эсхүл хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөө үзүүлэх эрхтэй; • Тухайн хуулийн этгээдийн дүрэм журам, баримт бичигт өөрчлөлт оруулах эрхтэй; • Тухайн хувь хүн эсхүл хуулийн этгээдийн үйл ажиллагаанд санал өгөх эрхтэй; • Бусад./ <p>Хэрэв тийм бол хянагчид зориулсан асуулгын хуудсыг хянагч тус бүрээр бөглөнө.</p>	

БАТАЛГАА

Миний бие/Бид дээр мэдүүлсэн мэдээллийг үнэн, зөв болохыг баталж байна.

Миний бие/Бид энэхүү баталгаанд чухал аливаа өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлнэ.

20___ оны ___ сарын ___ өдөр

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ: _____

БАЙГУУЛЛАГЫН НЭР: _____

*Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 344 дүгээр
тушаалын дөрөвдүгээр хавсралт*

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН ХЯНАГЧИЙН АСУУЛГА

Энэхүү хэсэгт эцсийн өмчлөгчийн хувь хүний 21-р асуулт, хуулийн этгээдийн 31-р асуултад дурдсан шинжүүдээс дор хаяж нэг шинжид хамаарч байгаа бол дараах асуулгыг бөглөнө. Үлдээсэн зай хангалтгүй бол нэмэлт хуудсан дээр бичин хавсаргана.

№	Асуулт	Хариулт
1.	Байгууллагатай холбоотойгоор хянагчийн шаардлагыг хангаж буй шалтгаан (жишээ нь, 10%-ийг эзэмшдэг гэх мэт)	
2.	Хянагчийн бүх захирлуудын нэр, албан тушаал	
3.	Хянагчийн бүх хянагчдын нэр, ямар агуулгаар тэднийг хянагч гэдэг болохыг дурдах.	
4.	Хүсэлт гаргагчийн байгууллагаас хуулийн дагуу эрх авсан санхүүгийн болон санхүүгийн бус бүх байгууллагын нэр (хянагч мөн тэрхүү байгууллагын хянагч эсвэл чухал хувьцаа эзэмшигч байх). Тухайн байгууллага бүрийн хувьд хянагч шаардлага хангахуйц гэдгийг харуулах.	
5.	Монгол Улс эсвэл гадаад улс оронд санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, виртуал хөрөнгө гаргах эсвэл виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхээр хянагч нь хяналтын байгууллагаас зөвшөөрөл авсан эсвэл авч байсан эсэх? Тийм бол дэлгэрэнгүй бичих. Тэрхүү эрхийг цуцлах, хүчингүй болгосон бол мөн дэлгэрэнгүй бичих.	
6.	Хянагч сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улс эсвэл гадаад улс оронд шүүхийн шийдвэрийн дагуу төлбөл зохих өрөө шүүхийн шийдвэр гарснаас хойш нэг жилийн дотор төлөөгүй тохиолдол гарч байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
7.	Хянагч сүүлийн 10 жилийн хугацаанд өөрийн зээлдүүлэгчидтэй тохиролцоо, хэлцэл хийх өөрөөр хэлбэл зээлдүүлэгчдийн өрийг бүрэн төлөөгүй тохиолдол гарч байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
8.	Монгол Улсад хянагчийн өмч хөрөнгөд хүлээн авагч томилж байсан эсвэл сүүлийн 10 жилийн хугацаанд бусад газар тэрхүү томилгоотой ижил төстэй томилгоог хийж байсан эсэх? Тийм бол тийнхүү томилсноос хойш тэрхүү хүлээн авагч эсвэл ижил төстэй этгээд үүргээ гүйцэтгэсээр байгаа эсэх талаар дэлгэрэнгүй бичих.	
9.	Монгол Улс хянагчийг сайн дурын үндсэн дээр татан буулгах тухай мэдэгдлийг өгч байсан уу эсвэл сүүлийн 10 жилийн хугацаанд тэрхүү мэдэгдэлтэй ижил мэдэгдлийг бусад газар өгч байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
10.	Монгол Улс эсвэл гадаад оронд хянагчийг хүчээр татан буулгах хүсэлт эсвэл сүүлийн 10 жилийн хугацаанд тэрхүү хүсэлттэй ижил хүсэлтийг бусад газар гаргаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
11.	Байцаагч эсвэл төрийн байгууллага, агентлаг, мэргэжлийн холбоо эсвэл Монгол Улс эсвэл гадаад орны хуулийн дагуу томилогдсон бусад зохицуулагч байгууллагын бусад эрх бүхий ажилтан хянагчийн бизнесийн үйл ажиллагаанд шалгалт хийж байгаа юу эсвэл өмнө нь тийнхүү шалгаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	

12.	Монгол Улсад эсвэл хаа нэгтээ зохицуулагч байгууллага ирээдүйд байгуулах гэрээтэй холбогдуулан хянагчийг буруушаах, хэрэгт татах, сануулах, сахилгын шийтгэл ногдуулах, нийтэд нээлттэй шүүмжилж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
13.	Хянагчийг Монгол Улсад эсвэл хаа нэгтээ мэргэжлийн байгууллага, эсвэл зохицуулалттай салбарын худалдааны нийгэмлэгт элсүүлэхээс татгалзаж байсан уу эсвэл хянагч хандсаныхаа дараа элсэх хүсэлт гаргахгүй байх шийдвэр гаргаж байсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
14.	Хянагч Монгол Улсад эсвэл хаа нэгтээ түүний эсвэл байгууллагын санхүүд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй шүүх ажиллагаанд оролцож байгаа эсвэл оролцох эсэх? Тийм бол дэлгэрэнгүй бичих.	
15.	Хянагч нь байгууллагатай аливаа гүйлгээ эсвэл хэлцэл (ногдол ашиг авах орохгүй)-д орсон эсвэл орохоор төлөвлөж байгаа юу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
16.	Хянагчийн бизнесийг үйл ажиллагаанд тухайн байгууллага баталгаа өгөх, баталгаа гаргах, баталгаажуулах эсвэл баталгаа өгөх, гаргах, баталгаажуулах гэж байгаа юу? Жишээ нь хянагч/групп компанийн зээлтэй холбогдуулан банк, санхүүгийн байгууллагад барьцаа өгөх гэх мэт. Тийм бол дэлгэрэнгүй бичих	
17.	Байгууллагын хэдэн ширхэг хувьцаа хянагч эсвэл салбар компанийн нэр дээр бүртгэлтэй байдаг? Бүртгэлтэй нэр, хувьцааны ангиллыг бичих	
18.	Хянагч эсвэл ижил группт байдаг компани эсвэл хамааралтай этгээд тухайн байгууллага (хянагч эсвэл салбар компанийн нэр дээр бүртгэгдээгүй)-ын хэдэн ширхэг хувьцааг сонирхож байна вэ? (үр шим хүртэх зорилгоор)	
19.	Хянагч эсвэл салбар компаниуд итгэл хүлээгч эсвэл нэрлэсэн хувьцаа эзэмшигчийн хувиар байгууллагад хувьцаа эзэмшдэг үү? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
20.	17, 18, 19-р асуултуудад өгсөн хариултуудад дурдсан байгууллагын хувьцааг ямар нэгэн этгээдэд шударгаар эсвэл хууль ёсоор санал болгох эсвэл барьцаалсан уу? Тийм бол дэлгэрэнгүй бичих	
21.	Тухайн байгууллага (эсвэл охин компани нь болох өөр байгууллага)-ын хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хэрэгжүүлэх саналын эрхийн хэдэн хувийг хянагч болон салбар компани хэрэгжүүлэх эсвэл хэрэгжилтийг нь хянах эрхтэй вэ?	

БАТАЛГАА

Миний бие/Бид дээр мэдүүлсэн мэдээллийг үнэн, зөв болохыг баталж байна.

Миний бие/Бид энэхүү баталгаанд чухал аливаа өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлнэ.

20___ оны ___ сарын ___ өдөр

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ: _____

БАЙГУУЛЛАГЫН НЭР: _____



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

“ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭГ ТОГТООХ, ТӨВЛӨРҮҮЛЭХ ЖУРАМ”-ЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.13, Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.17, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг нэгдүгээр хавсралтаар, Даатгалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хоёрдугаар хавсралтаар, Банк бус санхүүгийн байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг гуравдугаар хавсралтаар, Хадгаламж, зээлийн хоршооноос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг дөрөвдүгээр хавсралтаар, “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг төвлөрүүлэх журам”-ыг тавдугаар, “Үл хөдлөх эд хөрөнгө зүүчлалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг зургаадугаар хавсралтаар”, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээг долоодугаар хавсралтаар” тус тус баталсугай.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 121 дүгээр тогтоолоор нэмэлт, орсныг тусгав./

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 377 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан./

2. Энэхүү тогтоол Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох, төвлөрүүлэх журам батлах тухай” 158 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан журам, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн
211 дүгээр тогтоолын тавдугаар хавсралт

ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1.Энэ журмаар үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зүүчлалын байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс /цаашид “хөлс” гэх/-ийг төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 377 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./

Хоёр. Хөлс төвлөрүүлэх хэлбэр

2.1.Хөлсийг дараах үндсэн 3 хэлбэрээр төвлөрүүлнэ:

2.1.1.“хувь тооцож төвлөрүүлэх” гэж орлого, арилжаа болон нийт активын дүнгээс хувиар тооцсон дүнгээр жил бүр төвлөрүүлэхийг ойлгоно.

2.1.2.“тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх” гэж Хорооноос тогтоосон хэмжээ, ангилал, хуваарийн дагуу жил бүр төвлөрүүлэхийг ойлгоно.

2.1.3.“тухай бүр тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх” гэж хөлс төлөх үүрэг бүхий этгээд Хорооноос тогтоосон төрөл, хэмжээгээр тухайн үед гүйцэтгэсэн ажлын дүнд нэг удаа төвлөрүүлэхийг ойлгоно.

Гурав. Хөлс төвлөрүүлэх хугацаа, хөнгөлөх нөхцөл

3.1.Даатгагч, давхар даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчоос жил бүр төвлөрүүлэх хөлсийг 2 тэнцүү хувааж, эхний төлбөрийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, дараагийн төлбөрийг тухайн жилийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус төвлөрүүлнэ.

3.2.Хувь тооцож төвлөрүүлэх хөлсийг үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн хувьд арилжаа хийгдсэн тухай бүр, хөдөө аж ахуйн биржийн зүүчлагчийн хувьд тухайн 7 хоногийн нийт арилжааны дүнгээс тооцож дараа 7 хоногийн Мягмар гаригт багтаан тогтоосон хувиар тооцож төвлөрүүлнэ.

3.3.Жил бүр төвлөрүүлэх хөлсийг “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний

хэмжээг шинэчлэн тогтоох, төвлөрүүлэх журам” батлах тухай тогтоолын 1, 2, 3, 4, 6, 7 дугаар хавсралтуудад заасны дагуу жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор төвлөрүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 121 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсныг тусгав/

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 377 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан./

3.4.Хорооноос үйлчилгээ үзүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хөлс төлөх үүрэг бүхий этгээд нь тухай бүр төвлөрүүлэх хөлсийг шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногт багтаан төлнө.

3.5.Банк бус санхүүгийн байгууллага нь Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүрэг, аймгийн төвийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол жил бүр төвлөрүүлэх хөлсний 10 хувь, аймгийн төвөөс бусад суманд үйл ажиллагаа явуулж байгаа бол 20 хувь, Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны гишүүн бол 10 хувийн хөнгөлөлт тус тус эдэлнэ.

3.6.Хадгаламж зээлийн хоршоо нь Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооны гишүүн, 300.0 сая төгрөгөөс доош хэмжээний активтай бол жил бүр төвлөрүүлэх хөлснөөс бүрэн чөлөөлөгдөнө. Мөн холбооны гишүүн бусад хадгаламж, зээлийн хоршоо нь жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ.

3.7.Даатгалын зуучлагч нь Монголын даатгалын зуучлагчдын холбооны, даатгалын хохирол үнэлэгч нь Монголын хохирол үнэлэгчдийн холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ. Орон нутагт байгуулагдсан даатгалын хохирол үнэлэгчийн тухайн орон нутгаас олсон орлогыг хөлс тооцох дүнгээс хасч тооцно.

3.8.Үнэт цаасны брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлж буй компани нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ”.

3.9.Хувь тооцож төвлөрүүлэх хөлсийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд шимтгэлийн орлогын дүнгээс тухай бүр тогтоосон хувиар тооцож дараа сарын эхний 7 хоногийн Мягмар гаригт багтаан төвлөрүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 377 дугаар тогтоолоор нэмсэн./

3.10. Хөлсийг Төрийн сан банкин дахь Хорооны 900025001 тоот дансанд төвлөрүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 377 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./

Дөрөв. Хариуцлага.

4.1.Хөлсийг тогтоосон хугацаанд бүрэн төвлөрүүлээгүй, хугацаа хожигдуулж төвлөрүүлсэн хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

–oOo–

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн
211 дүгээр тогтоолын долоодугаар хавсралт

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧЭЭС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
1	Виртуал хөрөнгийн үйлчилгээ тус бүрээр бүртгүүлэх хүсэлт гаргах	1,000,000.00 төгрөг	Тухай бүр
2	Виртуал хөрөнгийн үйлчилгээ тус бүрээр үйл ажиллагааг сэргээх	5,000,000.00 төгрөг	Тухай бүр
3	- Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих;	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэлийн хувь 0.01-0.05% бол	нийт шимтгэлийн орлогын 1%
4	- Нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд арилжих;	0.06-0.15% бол	нийт шимтгэлийн орлогын 2%
5	- Виртуал хөрөнгийг шилжүүлэх;	0.16-0.25% бол	нийт шимтгэлийн орлогын 5%
		0.26%-с их бол	нийт шимтгэлийн орлогын 10%
6	виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах	10,000,000.00 төгрөг	Жил бүр
7	виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх	15,000,000.00 төгрөг	Жил бүр

/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 377 дугаар тогтоолоор нэмсэн/



Санхүүгийн зохицуулах хороо
Засгийн газрын IV байр
Бага тойруу - 3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар - 15160
Монгол улс

www.frc.mn